



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аймгийн ИТХ-ын захиалга болон Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын
2017 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийж
гүйцэтгэсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН

Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг хэвийн явуулах, зээлийг хугацаанд нь төлүүлэхийн тулд зээлийг олгосны дараа үр нөлөө муутай хяналт, шалгалт хийх бус олгохоос өмнөх судалгаа, шинжилгээ, үнэлгээний ажлыг бодитой болгох, хууль, эрх зүйн чадамж бүхий барьцаа хөрөнгө авч үлдэх, зээлийн мэдээллийг Монгол банкны мэдээллийн санд оруулах зэрэг огт хийгдэхгүй байгаа үр нөлөө бүхий арга хэмжээг холбогдох байгууллагуудаас нэгдсэн бодлого барьж хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Сүхбаатар сум

2017 оны 06 сар

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Сэлэнгэ аймаг дахь
Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор
Ч.Энхтуяа

Аудитын менежер
Б.Батмөнх

Ахлах аудитор
Б.Наранчимэг

Аудитор
Б.Эрдэнэзул
Ц.Отгонбаяр

Шинжээч
С.Баасансүрэн
А.Дашбат
Э.Эрдэнэзул
Ц.Уртнасан

Аудитын

тайлан, дүгнэлттэй
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл гарвал
70362442, 70363047,
70363040 дугаарын
утас, 70363040
дугаарын факсаар
харилцана уу.

ХАЯГ: Сэлэнгэ
аймгийн
ЗДТГ-ын байрны
өргөтгөлд

2017 оны 6 дугаар сар

Товчилсон үгийн тайлбар
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй
Үндсэн мэдээлэл

**1. Сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг хууль,
журамд заасны дагуу бүрдүүлж, төлөвлөж байна уу?**

1.1 Сангийн эх үүсвэрийг журамд заасны дагуу
бүрдүүлж, төлөвлөж байна уу?

1.2 Зээлийн хүүгийн орлогыг бүрэн төвлөрүүлж байна
уу?

**2. Сум хөгжүүлэх сангийн зээл олголт, ашиглалт үр
дүнтэй байна уу?**

2.1 Сум хөгжүүлэх сангаас зээл олгох төсөл,
хөтөлбөрийг журамд нийцүүлэн сонгон шалгаруулж
байна уу?

2.2 Зээлийн гэрээг зохих журмын дагуу байгуулж,
хэрэгжүүлэн ажиллаж байна уу?

2.3 СХС-гаас олгосон зээлийн ашиглалт үр дүнтэй байна
уу?

**3. Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг тайлагнах,
хяналт тавих үйл ажиллагаа үр дүнтэй байна уу?**

3.1 Орон нутгийн болон мэргэжлийн байгууллага, албан
тушаалтнууд хууль, журамд заасан эрх, үүргээ бүрэн
хэрэгжүүлж байна уу?

3.2. СХС-гийн хөрөнгийн бүртгэл, тайлагнал бодитой, үр
дүнтэй байна уу?

3.3. СХС-гийн үйл ажиллагаанд үр нөлөө бүхий дотоод
хяналт хийгдэж байна уу?

Илрүүлсэн зөрчил
Дүгнэлт
Зөвлөмж
Хавсралт судалгаа

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ИНХ	Иргэдийн Нийтийн хурал
СХС	Сум хөгжүүлэх сан
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
УИХ	Улсын Их Хурал

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудит хийх үндэслэл

Аймгийн ИТХ-ын захиалга, Монгол Улсын Ерөнхий аудиторт 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

2. Аудитын зорилт

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зээлийн эргэн төлөлт, хяналт түүний үр дүнд аудит хийж, гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах, санал, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэв. Уг зорилтын хүрээнд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Сум хөгжүүлэх сангийн орлогын эх үүсвэрийг журамд заасны дагуу бүрдүүлж, төлөвлөж байна уу?
2. Сум хөгжүүлэх сангийн зээл олголт, ашиглалт үр дүнтэй байна уу?
3. Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг тайлагнах, хяналт тавих, хариуцлага хүлээлгэх ажиллагаа журмын дагуу хийгдэж байна уу?

3. Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймгийн ХХААГ-ын болон сумдын СХС хариуцсан мэргэжилтнүүд, сумдын ИТХ, Засаг дарга, төрийн сангийн төлөөлөгч, нягтлан бодогч зэрэг албан тушаалтнууд, СХС-гийн 2011-2016 оны бүрдүүлэлт, төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалт, ашиглалт, хяналт, тайлагналтай холбоотой эрх зүйн актууд болон санхүү, нягтлан бодох бүртгэлийн баримт, материалуудыг хамруулав.

4. Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журам, аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, шаардлагатай нотлох баримт, лавлагаа тайлбар авах, судалгаа, тайлан мэдээг холбогдох байгууллагуудаас гаргуулж шинжлэн судалж, давтан тооцоолол хийх, санхүүгийн тайлан, хөрөнгийн данс, анхан шатны баримт, ажлын төлөвлөгөө, тайлантай тулган баталгаажуулах зэрэг арга зүй, горимыг хэрэгжүүлэв. Аудитын дүгнэлтэд дэмжлэг болох нотолгоо, холбогдох шинжилгээ, судалгааг тайланд хавсаргав.

5. Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 134 дугаар тогтоол “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”
- Аймаг, сумдын ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамжууд болон холбогдох бусад хууль эрхийн актууд

6. Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор Б.Наранчимэг, аудитор Б.Эрдэнэзул, Ц.Отгонбаяр, шинжээч С.Баасансүрэн, Ц.Уртнасан, А.Дашбат, Э.Эрдэнэзул нар 2017 оны 05 дугаар сарын 15-наас 07 дугаар сарын 01-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

Үндсэн мэдээлэл

Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолд “Сум хөгжүүлэх сан гэж сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, сэргээх болон шинээр ажлын байр бий болгох, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор хөнгөлөлттэй зээл олгоход зориулагдсан хөрөнгийг хэлнэ” гэж заасан байна.

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих үйл ажиллагаанд Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолоор баталсан журмыг мөрдөж байсан бөгөөд 2016 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн 153 дугаар тогтоолоор баталсан журмыг мөрдөж байна.

2011-2014 оны Төсвийн тухай хуульд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас Сум хөгжүүлэх санд санхүүжилт олгохоор батлагдсаны дагуу Сэлэнгэ аймагт Хөдөлмөрийн сайдын 4 удаагийн тушаалаар нийт 4,938.9 мянган төгрөгийн төсөв хуваарилагдсан байна.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2011-2016 онуудад нийт 8,529.3 сая төгрөгийн эх үүсвэр бүрдэж, 1452 иргэн, аж ахуйн нэгжид 8,151.5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгон, үүний үр дүнд шинээр 2246 байнгын болон түр ажлын байр бий болсон гэж дүгнэсэн байна.

Бүлэг 1**Сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу бүрдүүлж, төлөвлөж байна уу**

Зээлийг гэрээт хугацаанд нь төлүүлээгүйгээс 2,499,902.1 мянган төгрөгийн хөрөнгийг эргэлтэд оруулах, алданги, торгуулийн орлогыг тухай бүр тооцоолоогүйгээс 105,907.0 мянган төгрөгийн орлого нэмэгдүүлэх боломжуудыг алдсан байна.

1.1. Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн эргэн төлөлт хангалтгүйгээс нийт эх үүсвэрийн 41.4 хувийг эргэн төлөлтийн орлогоос бүрдүүлсэн бөгөөд аймгийн хэмжээнд 105,907.0 мянган төгрөгийн алдангийн орлого олох боломжийг алдсан байна.

Засгийн газрын 2011 оны 134-р тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 2.1-д “Сангийн хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ” гэж заасан байдаг. Үүнд:

- Улсын төсвөөс олгох сумын хөгжлийн сангийн эргэлтийн хөрөнгө
- Гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн буцалтгүй тусламж, хандив.
- Иргэн, аж ахуйн нэгжид сангаас олгосон зээлийн хүүгийн орлого

Дээрх тогтоолын дагуу сумдад үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжих, тэдэнд бага хүүтэй, уян хатан нөхцөлтэй зээл олгох, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор Сангийн сайд, Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан 2011 оны 100-А/59, Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайдын 2012 оны А/69, 2013 онд А/38 дугаар тушаалаар тус бүр 1,445,000.0 мянган төгрөгийн, 2014 оны А/141 дүгээр тушаалаар 603,900.0 мянган төгрөгийн зэрэг нийт 4,938,900.0 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор хуваарилан сумдын төрийн сан дахь СХС-гийн дансаар дамжуулан олгосон байна.

Сэлэнгэ аймгийн 17 сумдын “Сум хөгжүүлэх сан”-гийн дансны 2011-2016 оны орлогын гүйлгээг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1 /мянган төгрөг/

д/д	Сумдын нэр	Улсын төсвөөс олгосон санхүүжилт	Зээлийн эргэн төлөлт	Зээлийн хүүгийн орлого	аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн хандив	Алдангийн орлого	Нийт дүн
1	Алтанбулаг	255,000.0	173,922.6	17,597.1	-	-	446,519.7
2	Баруунбүрэн	168,000.0	168,678.4	4,896.4			341,574.8
3	Баянгол	255,000.0	184,060.5	16,152.3	30,000.0		485,212.8
4	Ерөө	255,000.0	166,367.2	17,734.1	-	1,166.2	440,267.5
5	Жавхлант	168,000.0	82,866.5	9,286.0		140.5	260,293.0
6	Зүүнбүрэн	168,000.0	105,307.5	3,522.8			276,830.3
7	Мандал	898,780.0	252,399.7	35,519.8	8,213.8		1,194,913.3
8	Орхон	185,060.0	280,916.2	13,118.5		6,908.0	486,002.7
9	Орхонтүүл	204,000.0	76,530.2	4,308.5	-		284,838.7
10	Сант	168,000.0	107,515.2	6,435.8			281,951.0
11	Сайхан	384,000.0	161,088.3	11,109.9			556,198.2
12	Сүхбаатар	901,000.0	1,002,274.6	68,805.4	-	32.5	1,972,112.5
13	Хушаат	175,060.0	60,970.2	3,939.0	-	-	239,969.2
14	Хүдэр	168,000.0	122,133.4	6,200.0			296,333.4
15	Түшиг	178,000.0	87,486.2	4,562.5	8,980.0	80.9	279,109.6
16	Цагааннуур	204,000.0	182,932.4	15,282.8	-	-	402,215.2
17	Шаамар	204,000.0	76,583.0	3,995.0		408.1	284,986.1
	Нийт дүн	4,938,900.0	3,292,032.1	242,465.9	47,193.8	8,736.2	8,529,328.0

Хандив, тусламжийн орлогын хувьд Баянгол сумын сангийн дансанд 2013 онд “Улсын тэргүүний сум”-ын шагналын 30,000.0 мянган төгрөг, Түшиг сумын сангийн дансанд 2014 онд “Рэдхил Монголиа” компанийн хандиваас 8,980.0 мянган төгрөг, 2015 онд Мандал сумын сангийн дансанд Хэрх, Түнхэл хөгжүүлэх сангийн үлдэгдэл 8,213.8 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Сангийн орлогын гүйлгээний ангиллыг графикаар харуулбал:

График 1



Графикаас үзэхэд нийт орлогын 57.9 хувийг улсын төсвөөс олгосон санхүүжилт, 38.6 хувийг зээлийн эргэн төлөлт, 2.8 хувийг хүүгийн орлого, 0.6 хувийг хандив, тусламжийн орлого, 0.1 хувийг алдангийн орлого эзэлж байна.

Баруунбүрэн, Орхон, Сүхбаатар, Цагааннуур сумд улсын төсвөөс олгосон санхүүжилтийн 89.7-151.8 хувьтай тэнцэх, Жавхлант, Мандал, Орхонтуул, Хушаат, Сайхан, Хушаат, Түшиг, Шаамар сумд 28.1-49.3 хувьтай тэнцэх, бусад сумд 62.7-72.7 хувьтай тэнцэх нийт **3,292,032.1** мянган төгрөгийн орлогыг зээлийн эргэн төлөлтөөс төвлөрүүлсэн байна. / Хавсралт 1-д дэлгэрэнгүй харуулав./

Эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн зээлд ногдуулах алданги, торгуулийн орлогыг бүх сумд тусад нь тооцож бүртгээгүй бөгөөд санхүүгийн тайлан, холбогдох яаманд явуулдаг мэдээ тайланд тусгаагүй байлаа.

Засгийн газрын 2011 оны 134-р тогтоолын 2-р хавсралтаар батлагдсан зээлийн гэрээний загварын 2.4-д зээлийн эргэн төлөлтийг хуваарийн дагуу төлөөгүй, хугацаа хэтрүүлсэн тохиолдолд торгууль ногдуулна гэж заасан боловч сумдууд гэрээний дагуу алданги, торгууль тооцоогүйгээс 105,907.0 мянган төгрөгийн алдангийн орлого, бүрэн төлж дуусах хугацаа болсон зээлээс 2,499,902.1 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэх боломжийг алдсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

2011-2013 оны хугацаа хэтэрсэн зээлд тооцсон алданги:

Хүснэгт 2 /мянган төгрөгөөр/

д/д	Сумдын нэр	Бүрэн төлж дуусах хугацаа болсон зээл		Гэрээнд заасан алданги тооцох хувь	Аудитын тооцоосон алданги
		тоо	дүн		
1	Алтанбулаг	22	102,468.4	сарын 0.2%	1,746.0
2	Баруунбүрэн	24	55,628.0	сарын 0.3%	1,902.1
3	Баянгол	12	171,933.4	сарын 0.5%	14,663.4
4	Ерөө	44	113,471.5	хүүний 20%	750.1
5	Жавхлант	31	97,775.1	сарын 0.05%	450.7
6	Зүүнбүрэн	63	82,759.2	сард төлөх үндсэн зээлийн төлбөрийн 10 %	8,006.4
7	Мандал	25	675,861.1	сарын 0.05%	3,560.9
8	Орхон	16	11,120.5	сарын 3%	510.5
9	Орхонтуул	27	135,862.9	сарын 0.016%	312.6
10	Сант	21	66,340.4	2011 онд сарын 0.3%, 2013 онд сарын 0.5 %	3,137.9
11	Сайхан	72	251,595.3	сарын 0.3 %	9,994.3
12	Сүхбаатар	85	250,699.1	хугацаа заагаагүй, төлөгдөөгүй зээлийн үлдэгдлээс 10%	25,070.0
13	Хушаат	33	110,137.4	сарын 0.5%	6,112.2
14	Хүдэр	37	62,036.6	сарын 0.25-0.5%	3,095.9
15	Түшиг	48	99,452.6	2011 онд сарын 0.2%, 2013 онд сарын 0.3 %	21,871.1
16	Цагааннуур	22	64,727.8	сарын 1%	4,214.3
17	Шаамар	45	148,032.8	сарын 0.05%	508.6
Нийт дүн		627	2,499,902.1		105,907.0

Дээрх хүснэгтээс харахад сумдууд зээлийн гэрээнд алданги, торгуулийг харилцан адилгүй хувь, хэмжээгээр тооцохоор тусгаж ирсэн байна.

Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан журмын 1.7-д “Зээлдэгч зээлийг хугацаандаа төлөөгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төлөөгүй зээлийн дүнгийн 0,5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр алданги төлнө. Алдангийн хэмжээг сумын Засаг дарга болон зээлдэгчтэй байгуулах Зээлийн гэрээнд тодорхой тусгана” гэж заасан учир цаашид зээл олгохдоо уг заалтыг хэрэгжүүлэн ажиллах нь зүйтэй юм.

Сангийн сайдын 2016 оны 02 сарын 16-ны өдрийн 4-3/760 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн “Улсын төсвөөс жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор өмнөх онуудад олгосон санхүүжилт нь тухайн ондоо улсын төсвийн зарлага болсон бөгөөд энэ эх үүсвэрийг ашиглан зээлийн эргэлтийн сан хэлбэрээр үйл ажиллагааг орон нутаг хариуцан эрхэлж байгаа тул сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт болон зээл олголтыг орон нутгийн төсөвт тусган төлөвлөж, хэрэгжилтийг хангах, тайлагнах” гэсэн зөвлөмж болон Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.3.1-д “сангийн төсвийг баталж, сангаас тухайн жилд нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг тогтоох” гэсэн заалтын дагуу 2016 оноос эхлэн сум хөгжүүлэх сангийн орлого, зарлагыг төсвийн бүрэлдэхүүн хэсэг болгож, сумын ИТХ-ын тогтоолоор баталсан байна.

Сумдын СХС-гийн 2016 оны батлагдсан төсөв, гүйцэтгэл :

Хүснэгт 3 /мянган төгрөгөөр/

д/д	Сумдын нэр	Сумын ИТХ-ын тогтоолын огноо, №	Сумын ИТХ-ын тогтоолоор		Гүйцэтгэл		
			орлого	зарлага	Орлого зээлийн эргэн төлөлт	Зарлага зээл олголт	үйл ажиллагааны зардал
1	Алтанбулаг	2016.03.28 №109	134,163.3	134,163.3	37,104.2	7,000.0	544.8
2	Баруунбүрэн	2016.05.05-№09	90,057.0	90,057.0	28,344.0	18,000.0	-
3	Баянгол	2016.04.11-№89	158,939.2	158,939.2	50,827.9	-	799.4
4	Ерөө	2016.04.08 №90	130,000.0	130,000.0	46,306.6	48,000.0	-
5	Жавхлант	2016.04.19 №03	38,770.4	38,770.4	10,357.9	33,000.0	650.3
6	Зүүнбүрэн	2015.03.30 №04	170,000.0	170,000.0	34,175.5	17,000.0	-
7	Мандал	2016.04.11 №103	311,800.7	311,800.7	70,747.1	41,500.0	1,370.0
8	Орхон	2015.12.18 №109	71,706.0	71,706.0	51,460.0	-	-
9	Орхонтуул	-	-	-	9,867.5	-	-
10	Сант	2016.11.06 № 81	40,000.0	40,000.0	32,936.4	37,983.0	-
11	Сайхан	2016.10.28 №66	40,000.0	40,000.0	58,038.7	40,000.0	1,060.4
12	Сүхбаатар	2016.12.19 №12	432,620.0	432,620.0	245,176.4	210,500.0	1,386.0
13	Хушаат	2016.03.14 №07	150,244.2	150,244.2	11,028.5	1,000.0	515.0
14	Хүдэр	2016.07.20 №169	87,070.0	87,070.0	28,583.1	-	-
15	Түшиг	2016.03.09 №113	103,265.0	103,265.0	11,637.9	17,500.0	647.0
16	Цагааннуур	2016.02.24 №84	126,641.6	126,641.6	38,384.1	45,000.0	200.0
17	Шаамар		187,540.6	187,540.6	22,624.4	36,500.0	50.0
Нийт дүн			2,272,818.0	2,272,818.0	787,600.2	552,983.0	7,222.9

Хүснэгтээс харахад Орхонтуул сум СХС-гийн орлого, зарлагыг төсвийн бүрэлдэхүүн хэсэг болгож төлөвлөөгүй бол Шаамар сум төлөвлөсөн боловч ИТХ-ын тогтоолоор баталгаажуулаагүй байна.

Сант, Сайхан, Сүхбаатар сумдууд 2016 оны эцсээр СХС-гийн орлогын гүйцэтгэлд үндэслэн орлого, зарлагыг батлуулсан бол бусад сумд ирэх онд зээлийн эргэн төлөлтөөс төвлөрөх ёстой орлогын дүнд үндэслэн сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг төлөвлөсөн боловч зээлийн эргэн төлөлт хангалтгүйгээс төлөвлөсөн орлого бүрэн төвлөрөөгүй байна.

1.2 Зээлийн эргэн төлөлт хангалтгүйгээс хүүгийн орлого 44.0 хувиар буюу 199,729.1 мянган төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.

Засгийн газрын 2011 оны 134-р тогтоолын 2-р хавсралтаар батлагдсан зээлийн гэрээний загварын 2-д зээлдэгчийн эрх, үүргийг тусгасан бөгөөд 2.1-д “Зээлийн үндсэн төлбөрийг дор дурдсан зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлж дуусгана” гэж заасан байдаг. Мөн уг журмаар батлагдсан зээлийн эргэн төлөлтийн хуваарь нь зээлийн үндсэн төлбөр, хүүгийн тооцооллыг хийхэд шаардлага хангахгүй байсан тул бүх сумдууд 2013 оноос хойш зээлийн эргэн төлөлтийн хуваарийг арилжааны банкны жишгийн дагуу хийсэн байна.

Аудитын явцад 2011-2016 онд олгосон зээл, зээлийн эргэн төлөлтийг тулган баталгаажуулахад зээлийн хүүгийн орлогын 44.0 хувь болох 199,729.1 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4 /мянган төгрөгөөр/

д/д	Сумдын нэр	Хүүгийн орлого			
		төлбөл зохих	төлсөн	зөрүү	хувиар
1	Алтанбулаг	21,097.0	17,597.1	3,499.9	16.6
2	Баруунбүрэн	14,831.4	4,896.4	4,326.0	29.2
3	Баянгол	19,685.2	16,152.3	3,828.0	19.4
4	Ерөө	23,060.7	17,734.1	5,326.6	23.1
5	Жавхлант	17,946.8	9,285.9	8,660.9	48.3
6	Зүүнбүрэн	7,222.1	3,522.8	3,699.3	51.2
7	Мандал	75,285.2	35,519.8	39,765.4	52.8
8	Орхон	15,974.3	13,118.5	2,855.8	17.9
9	Орхонтуул	26,858.1	4,308.5	15,904.8	59.2
10	Сант	11,957.7	6,435.8	5,521.9	46.2
11	Сайхан	38,479.0	11,109.9	27,369.1	71.1
12	Сүхбаатар	112,511.7	68,805.4	43,706.3	38.8
13	Хушаат	8,839.9	3,939.0	4,900.9	55.4
14	Хүдэр	8,161.7	6,200.0	1,961.7	24.0
15	Түшиг	11,907.3	4,562.6	7,344.7	61.7
16	Цагааннуур	23,053.2	15,282.8	7,770.4	33.7
17	Шаамар	17,282.4	3,995.0	13,287.4	76.9
Нийт дүн		454,153.7	242,465.9	199,729.1	44.0

Хүснэгтээс харахад бүх сумдууд сангаас олгосон зээлийн хүүгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн бөгөөд Орхонтуул, Сайхан, Түшиг, Шаамар сумдууд төвлөрүүлбэл зохих орлогын 59.2-76.9 хувийг төвлөрүүлээгүй байна.

Сумдууд зээлийн эргэн төлөлтөөс хуримтлагдсан хүүг эхэлж тооцож авалгүйгээр үндсэн зээлээс хасалт хийдэг нь хүүгийн авлага нэмэгдэх, хүүгийн орлого буурах эрсдэлийг бий болгож байна.

Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан шинэ журмын 4.7-д *“Иргэн, хуулийн этгээд авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө”* гэж зээлдэгчийн үүргийг тодорхой тусгаж өгсөн байна.

Иймд сум хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтэн болон нягтлан бодогч нар зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлогыг үнэн зөв, бодитой тооцож, бүртгэл тайланд тусгах шаардлагатай байна.

Бүлэг 2

Сум хөгжүүлэх сангийн зээл олголт, ашиглалт үр дүнтэй байна уу

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг ижил чиглэлийн олон үйл ажиллагаанд хэт жижиглэн олгож байгаа нь жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, өргөтгөхөд үр дүнгээ өгөхгүй байна.

2.1. Сум хөгжүүлэх сангаас олгох зээлийг хэт жижиглэн, нэг төрлийн чиглэлд олон тоогоор олгож байгаа нь жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, өргөтгөх, ажлын байр нэмэгдүүлэх зорилгыг хангаж чадахгүй байна.

Засгийн газрын 2011 оны 134, 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-д тухайн орон нутагт жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох зорилгод нийцүүлэн тэргүүлэх чиглэлийг

батлах¹, төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг 7 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр томилох²-оор зохицуулжээ.

Ихэнх сумдын ИТХ-аас жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах, үйл ажиллагааг нь өргөтгөх, шинээр ажлын байр бий болгохоор³ тэргүүлэх чиглэлийг баталж, энэ чиглэлээр зээл олгож ирсэн бол Сүхбаатар сум 2014, 2015 онд сангийн зорилгод нийцээгүй дэд бүтцийн чиглэлээр *гэрэлтүүлэг бий болгох, ногоон байгууламж нэмэгдүүлэх, хайс хашаа хийх, барих, инженерийн дэд бүтцэд холбогдох, шугам сүлжээ татах, албан байгууллага айл өрхийн гадна талын тохижилт, гэрлэн чимэглэл хийх* 52 төсөл, арга хэмжээнд 235,678.0 мянган төгрөгийн зээл олгохоор шийдвэрлэсэн байна.

Сайхан сум 2011, 2012 онд, Сүхбаатар сум 2012 онд, Мандал сум 2015 онд, Хушаат сум 2011 онд тус тус тэргүүлэх чиглэлээр батлалгүйгээр зээл олгосон байна.

Аймгийн хэмжээний зээл олгохоор дэмжигдсэн нийт төслийн 65.0 хувь нь шинээр үйл ажиллагаа эхлэхэд, 35.0 хувь нь үйл ажиллагаагаа өргөтгөхөд чиглэсэн бөгөөд эргэлтийн хөрөнгө бэлтгэхэд 49.1 хувийг, тоног төхөөрөмж авахад 30.0 хувийг, машин техник худалдан авах, барилга барихад 6.8 хувийг, бусад зориулалтаар 14.7 хувийг тус тус зарцуулахаар төсөл ирүүлсэн байна.

Зээл авахаар дэмжигдсэн төслийн зориулалтыг хүснэгтээр харуулбал:
Хүснэгт 5 /мянган төгрөгөөр/

Ерөнхий мэдээлэл				Зээлийн зориулалт										ЖДҮ																		
Д/д	Сумын нэр	Нийт олгосон зээл		Эргэлтийн хөрөнгө		Тоног төхөөрөмж		Машин техник, барилга		Үндсэн хөрөнгө бусад		Ажлын хөлс		Шинээр байгуулсан		Өргөтгөсөн																
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн															
1	Алтанбулаг	51	409,000	20	171,000	19	135,000	8	50,000	4	53,000			30	248,500	21	160,500															
2	Баруунбүрэн	120	329,800	50	154,200	44	115,600	4	6,400	22	53,600			115	304,200	5	25,600															
3	Баянгол	29	426,700	2	17,000	11	163,200	12	189,500		-	4	57,000	17	264,500	12	162,200															
4	Ерөө	74	438,440	13	84,800	56	323,420	3	18,220	2	12,000			72	416,440	2	22,000															
5	Жавхлант	56	253,170	14	39,900	32	137,540	3	14,000.0	7	61,730			56	253,170																	
6	Зүүнбүрэн	93	256,700	93	256,700									2	4,500	91	252,200															
7	Мандал	70	1,180,302	48	510,202	21	659,300	1	10,800					60	996,202	10	184,100															
8	Орхон	78	432,120	55	295,120	20	120,000	2	12,000	1	5,000			48	330,160	30	101,960															
9	Орхонтуул	76	281,250	51	194,500	4	15,500	7	51,200	14	20,050			70	160,050	6	121,200															
10	Сайхан	116	529,050	29	86,400	66	321,600	1	10,000	20	111,050			95	438,550	21	90,500															
11	Сант	60	277,983	34	126,483	18	102,600	2	6,400	6	42,500			32	117,900	28	160,083															
12	Сүхбаатар	356	1,915,197	100	508,950	85	510,042	48	275,500	123	620,705			137	749,133	219	1,166,064															
13	Түшиг	83	275,500	68	209,500	14	64,000	1	2,000					71	234,000	12	41,500															
14	Хушаат	50	206,300	50	206,300									14	57,600	36	148,700															
15	Хүдэр	85	258,500	34	94,000	30	114,500	10	23,000	11	27,000			51	171,000	34	87,500															
16	Цагааннуур	64	390,000	15	50,500	43	270,500	3	47,000	3	22,000			52	300,500	12	89,500															
17	Шаамар	81	291,500	81	291,500									81	291,500																	
Аймгийн дүн		1542	8,151,512	757	3,297,055	463	3,052,802	105	716,020	213	1,028,635	4	57,000	1003	5,337,905	539	2,813,607															
Дүн хувиар		100		100		49.1		40.4		30		37.5		6.8		8.8		14		12.6		0.3		0.7		65.0		65.5		35.0		34.5

¹ Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 3.1.1. сангийн хөрөнгөөр зээл олгохтой холбогдуулан сумын хөгжлийн тэргүүлэх чиглэлийг орон нутагт жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох зорилгод нийцүүлэн тодорхойлох;

3.3. Төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг сумын ИТХ-ын тогтоолоор 7 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллуулна. Төсөл сонгон шалгаруулах зөвлөлийг сумын Засаг дарга ахлах бөгөөд зөвлөлийн 3 гишүүн нь тухайн сумын иргэний төлөөлөл байна.

² Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 3.3.3 сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг тухайн сумын Засаг даргаар ахлуулан, ЗДТГ-ын жижиг дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо, банк болон баг тус бүрээс нэг иргэний төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулах;

³ Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолоор баталсан журмын 1.5. Сангийн хөрөнгө нь сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, сэргээх болон шинээр ажлын байр бий болгох, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор хөнгөлөлттэй зээл олгоход зориулагдана.

Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан журмын 1.2. Сангийн хөрөнгийг сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, шинэчлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, хөнгөлөлттэй зээл олгоход зориулан зарцуулна.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2011-2016 онуудад нийт 1542 төсөлд 8,151,512.0 мянган төгрөгийн зээл олгосноос мал аж ахуйн чиглэлд 20.2 хувийг, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлд 15.4 хувийг, үйлчилгээний чиглэлд 14.4 хувийг, газар тариалангийн чиглэлд 10.9 хувийг, хүнсний үйлдвэрлэлийн чиглэлд 10.2 хувийг, барилгын чиглэлд 5.8 хувийг, худалдааны чиглэлд 4.9 хувийг, бусад чиглэлд 18.1 хувийг олгосон байна.

Олгохоор шийдвэрлэгдсэн төслийг үйл ажиллагааны чиглэлээр нь харуулбал:

Хүснэгт 6 /мянган төгрөгөөр/

Д/д	Сумын нэр	Нийт олгосон зээл		Хүнсний үйлдвэр		Хөнгөн үйлдвэр		Газар тариалан		Мал аж ахуй		Барилга		Худалдаа		Үйлчилгээ		Бусад		Журмын зорилгод нийцээгүй	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Алтанбулаг	51	409,000	6	34,000	13	81,000	5	40,000	8	58,500	4	24,000	0	-	0	-	15	171,500	0	-
2	Баруунбүрэн	120	329,800	5	15,000	-	-	11	37,000	63	152,400	4	6,400	16	48,600	21	70,400	-	-	-	-
3	Баянгол	29	426,700	-	-	2	22,700	3	27,000	2	38,000	3	70,000	1	17,000	6	90,000	12	162,000	-	-
4	Ерөө	74	438,440	17	83,650	27	154,820	2	14,000	3	27,000	-	-	1	6,300	3	19,000	21	133,670	-	-
5	Жавхлант	56	253,170	-	-	-	-	9	60,300	10	34,600	9	38,900	11	48,640	2	3,500	15	67,230	-	-
6	Зүүнбүрэн	93	256,700	20	52,700	4	16,500	22	46,900	21	50,600	1	3,000	4	16,900	-	-	21	70,100	-	-
7	Мандал	70	1,180,302	15	197,400	17	505,002	13	109,300	6	91,500	1	4,000	-	-	16	244,300	2	28,800	-	-
8	Орхон	78	432,120	7	60,400	6	17,500	13	57,500	33	177,060	1	3,500	4	38,600	13	72,560	1	5,000	-	-
9	Орхонтүүл	76	281,250	2	10,300	14	62,800	-	-	24	81,900	-	-	7	27,000	20	70,250	9	29,000	-	-
10	Сайхан	116	529,050	18	79,100	17	79,600	15	49,000	17	62,000	-	-	12	70,000	27	137,850	10	51,500	-	-
11	Сант	60	277,983	6	36,500	5	39,000	8	29,000	18	69,183	1	3,500	2	3,500	2	13,000	18	84,300	-	-
12	Сүхбаатар	356	1,915,197	19	95,278	35	212,350	50	259,670	117	594,149	2	13,900	13	70,000	50	330,172	18	104,000	52	235,678
13	Тушиг	83	275,500	-	-	1	3,500	29	108,500	26	75,000	2	5,000	2	11,000	3	6,000	20	66,500	-	-
14	Хушаат	50	206,300	5	15,000	4	12,500	3	16,500	20	86,700	4	24,500	-	-	7	25,500	7	25,600	-	-
15	Хүдэр	85	258,500	23	66,500	11	29,000	11	22,000	4	12,000	11	48,500	6	17,000	-	-	19	63,500	-	-
16	Цагааннуур	64	390,000	17	85,000	5	20,000	-	-	1	5,000	11	86,000	-	-	12	83,000	18	111,000	-	-
17	Шаамар	81	291,500	-	-	-	-	3	10,500	11	32,000	45	145,500	5	23,000	3	11,500	14	69,000	-	-
Аймгийн дүн		1542	8,151,512	160	830,828.0	161	1,256,272.0	197	887,170.0	384	1,647,592.0	99	476,700.0	84	397,540.0	185	1,177,032.0	220	1,242,700.0	52	235,678.0
Дүн хувиар		100	100	10.4	10.2	10.4	15.4	12.8	10.9	24.9	20.2	6.4	5.8	5.4	4.9	12.0	14.4	14.3	15.2	3.4	2.9

Хүснэгтээс харахад хүнсний үйлдвэрлэлийн чиглэлд нэг суманд дунджаар 23 хүртэлх, газар, тариалангийн чиглэлд 50 хүртэлх, мал аж ахуйн чиглэлд 117 хүртэлх гэх мэт нэг төрлийн чиглэлд хэтэрхий олон тооны зээл олгосон байна.

Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн хэмжээ:

Хүснэгт 7

д/д	Зээлийн хэмжээ	Зээлдэг чийн тоо	Мөнгөн дүн /мян.төг/	Эзлэх хувь
1	1,000.0 мянган төгрөг хүртэл	109	100,020.0	1.2
2	1,000.0-3,000.0 мянган төгрөг хүртэл	551	1,254,984.0	15.4
3	3,000.0-5,000.0 мянган төгрөг хүртэл	468	2,068,823.0	25.4
4	5,000.0-10,000.0 мянган төгрөг хүртэл	285	2,178,433.0	26.7
5	10,000.0-15,000.0 мянган төгрөг хүртэл	63	849,250.0	10.4
6	15,000.0-20,000.0 мянган төгрөг хүртэл	30	527,830.0	6.5
7	20,000.0-50,000.0 мянган төгрөг хүртэл	32	857,172.0	10.5
8	50,000.0-100,000.0 мянган төгрөг хүртэл	3	150,000.0	1.8
10	150,000.0-аас дээш мянган төгрөг	1	165,000.0	2.0
Нийт дүн		1542	8,151,512.0	100.0

Аймгийн хэмжээгээр 1,000.0-5,000.0 мянган төгрөг хүртэлх 1128 төсөлд нийт зээлийн 73.2 хувьтай тэнцэх 3,423,827.0 мянган төгрөг олгосон бол 5,000.0-20,000.0 мянган төгрөг хүртэлх 378 төсөлд 3,555,513.0 мянган төгрөг, 20,000.0 мянган

төгрөгөөс дээш 36 төсөлд 1,172,172.0 мянган төгрөгийн зээлийг тус тус олгосон байна.

Дээр дурдсанчлан тус сангаас олгож буй зээлд аль болох олон хүнийг хамруулах бодлого барьж, нэг төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлд зээлийг хэт жижигрүүлэн олгож байгаа нь жижиг дунд үйлдвэрийг дэмжих, тэргүүлэх чиглэлийг жигд хөгжүүлэх гэхээсээ илүү иргэдийн өдөр тутмын амьжиргаанд зориулан олгож байгаа мэт харагдаж, зээлийн үр дүн, үр нөлөөг бууруулж байна.

Сум хөгжүүлэх сангаас зээл олгох төслийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг сумын ИТХ-аас Засаг даргаар ахлуулан 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр, 1-6 жилийн хугацаатайгаар томилж иржээ.

Ихэнх сумд сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүдийг иргэдээс сонгон шалгаруулж шинэчлээгүй, хуралд тогтмол 1-3 гишүүн оролцдоггүй, хурлын тэмдэглэл, шийдвэрийг гарын үсгээр баталгаажуулаагүй, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргаагүй, иргэдээс төсөл хүлээн авч, хариу өгсөн тухай бүртгэл хөтлөөгүй байгаа зэрэг нь сонгон шалгаруулалт нийтэд ил тод, шударга явагдахгүй байх, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг үүсгэж байна. Тухайлбал:

1. Орхонтуул, Шаамар сумдад анх 2011 онд томилогдсон зөвлөлийн гишүүдийг өөрчлөөгүй, Алтанбулаг, Сүхбаатар сум 2011 оноос хойш дөнгөж 1 иргэний төлөөллийг өөрчилсөн, Цагааннуур сум 2016 онд л шинэчилсэн байна. Өөрөөр хэлбэл дээрх сумдын сонгон шалгаруулах зөвлөл 6 жил нэг бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж ирсэн бол бусад сумд 1-2 жилд 3-6 гишүүнийг өөрчилж, зөвлөлийг шинэчилж ажилласан байна.
2. Баянгол, Сант, Зүүнбүрэн сумдаас бусад сумдын төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу⁴ ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргаагүй байна.
3. Сум хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар иргэдээс ирүүлсэн төслийг Жавхлант сум 2013, 2015 онуудад, Шаамар сум 2015 онд хүлээн авч бүртгэл хөтлөн, төслийг үнэлж, шалгараагүй төсөлд хариу өгч байсан бол бусад сумд ирсэн төслийг дарааллаар нь бүртгэж аваагүй, татгалзах үндэслэлийг хэлэлцэн, албан ёсоор хариу өгөөгүй байна.
4. Сүхбаатар сумын сонгон шалгаруулах зөвлөлийн 4 нь тус сумын ЗДТГ-ын ажилтнууд бөгөөд 3 иргэний төлөөллөөс 1 гишүүн нь хуралд огт оролцож байгаагүй, зарим хурлын протоколд 1-4 гишүүний гарын үсэг дутуу, хурлаар хэдэн төсөл хэлэлцсэн, ямар үндэслэлээр татгалзсан нь тодорхойгүй, зөвхөн дэмжигдэх зээлүүдийг хэлэлцсэн тухай тэмдэглэл хөтлөгдсөн байна.
5. Цагааннуур сумын сонгон шалгаруулах зөвлөлийг ИТХ-ын тогтоолоор өөрчлөн батлаагүй байхад 2014, 2015 онуудад 4 иргэнийг ээлжлэн 3 удаагийн хуралд оролцуулсан байна.
6. Сүхбаатар сум зээлийн эргэн төлөлт, эх үүсвэрийг үл харгалзан нэг удаагийн сонгон шалгаруулах хурлаар олон тооны төслийг дэмжсэн шийдвэр гаргаж, зээлийг жил дамнуулан хуваан олгож байгаа нь тухайн төслийн үр ашгийг бууруулж, иргэдэд хүлээлт үүсгэж байна. Зээл олголтын гүйлгээг шийдвэр гарсан дарааллаар нь хийгээгүй байна.

⁴ 8.1. Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана.

Төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн шийдвэрийг хурлын тэмдэглэлээр баталгаажуулж байгаа ч ихэнх сумдын хурлын тэмдэглэл албан бичиг хөтлөлтийн стандарт шаардлага хангаагүй, гарын үсгээр бүрэн баталгаажгаагүй, шалгарсан болон шалгараагүй төслийн үндэслэлийг тодорхойлоогүй, иргэдийн оролцоо хангалтгүй зэрэг зөрчил нийтлэг оршиж байна.

Журамд заасны дагуу⁵ төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог ханган ажиллах ёстой байдаг. Гэвч дараах 4 сумаас бусад сумд иргэдийн оролцоог хангаж ажиллаагүй байна.

- *Баянгол, Орхонтуул сумд жил бүр сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг ард иргэдээс саналын хуудсаар авч, БИНХ-р хэлэлцүүлэн эрэмбэлж, хамгийн олон санал авсан төслийг шалгаруулж, тогтоол гаргаж байсан байна.*
- *Түшиг сум 2013 оны 4-р сард багийн ИНХ-аар нээлттэй хэлэлцүүлгийг ганц удаа зохион байгуулж, иргэдээр төслийг нь хамгаалуулсан байна.*
- *Зүүнбүрэн сум 2013 онд бүх ирсэн төслийг багийн ИНХ-аар хэлэлцүүлэн эрэмбэлж, төсөл сонгон шалгаруулах зөвлөлд хүргүүлсэн байна.*

Төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөл нь зээлдэгчийн төлбөрийн болон үйл ажиллагаа явуулах чадваруудыг нарийвчлан бодитой үнэлж, судалгаа хийгээгүй, сонгон шалгаруулсан төслийн үзүүлэлт нь тодорхой бус байхад зээл олгох шийдвэр гаргаж байгаа нь зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд сөргөөр нөлөөлж байна.

Аудитын явцад журамд заасан шалгуурын дагуу бүрдүүлсэн баримт материал, зээлдэгчдийн хувийн хэргийг тулган баталгаажуулахад дараах зөрчил оршиж байлаа. Үүнд:

1. *Баянгол, Сүхбаатар, Цагааннуур сумд тус бүр 1, Мандал сум 2, Зүүнбүрэн сум 5, Хушаат сум 7, Сайхан сум 20 гэх мэт 7 сумын 37 зээлдэгчийн хувийн хэрэгт ирүүлсэн төслийг хавсаргаагүй, ямар төсөлд сонгон шалгаруулалт хийсэн нь тодорхойгүй байна.*
2. *Мандал сум 1 иргэний 3,000.0 мянган төгрөгийн, Сүхбаатар сум 2 иргэний 25,000.0 мянган төгрөгийн төслийн үр ашгийн тооцоо хийгдээгүй, зарим үзүүлэлт тодорхойгүй байхад сонгон шалгаруулалт хийсэн байна.*
3. *Сүхбаатар суманд 1 иргэн 10,000.0 мянган төгрөгийн зээл хүссэн байхад 15,000.0 мянган төгрөгийг шийдвэрлэж, олгосон байна.*
4. *Мандал сум 1, Сайхан сум 2, Зүүнбүрэн сум 8, Сүхбаатар сум 9, Хушаат сум 13, Алтанбулаг сум 16, Ерөө сум 17, Цагааннуур сум 19, Сант сум 28 зэрэг нийт 113 зээлдэгчид багийн Засаг даргын тодорхойлолт хийгдээгүй, тухайн сумын оршин суугч мөн эсэхийг нотлох баримтгүйгээр зээл олгох шийдвэр гаргасан байна.*
5. *Журмын 4.2.2-т заасан “сум хөгжүүлэх сан болон жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урьд авсан зээлийн өргүй байх;” гэсэн шалгуурыг Сант сум 2013 оноос эхлэн мөрдөж, сумын ЗДТГ-ын жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн, татварын байцаагч, санхүүгийн албаны дарга болон суманд байрлалтай бүх банкуудыг хамруулан тойрох хуудсаар баримтжуулж байгаа бол бусад сумд уг шалгуурыг харгалзаж үзээгүй байна.*

⁵ Засгийн газрын 134 дүгээр тогтоолоор батлагдсан журмын ИТХ-ын эрх үүргийн 3.1.4. төсөл сонгон шалгаруулахад сумын иргэдийн саналыг авах, түүнийг харгалзан үзэх боломжийг бүрдүүлэх;

Засаг даргын эрх үүргийн 3.2.1. сумын хэмжээнд төсөл сонгон шалгаруулахад иргэдийн оролцоог хангах арга хэмжээ авах;

6. Бүх сумдын сонгон шалгаруулах зөвлөл нь төсөл ирүүлсэн иргэд, аж ахуйн нэгжүүдийн зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах, зээлээ хугацаанд нь төлөх төлбөрийн чадвартай эсэхийг бодитой үнэлээгүй, орлогын эх үүсвэрийг зөвхөн 1-2 банкны тодорхойлолт, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг харгалзан үзэж шийдвэрлэж байгаа нь зээлийн ашиглалт, эргэн төлөлт хангалтгүй байх нэг үндэс болж байна. 11 сумын 752 зээлдэгчийн хувийн хэрэгт нийгмийн даатгалын шимтгэл төлсөн, шинээр ажлын байр бий болгосныг нотлох гэрээг хавсаргаагүй, 12 сумын 395 зээлдэгчийн хувийн хэрэгт ямар нэгэн банкны лавлагаа хавсаргаагүй байлаа.

Дараах 8 сум журмын холбогдох заалтыг зөрчиж⁶ сонгон шалгаруулах зөвлөлийн болон Засаг даргын шийдвэргүйгээр 908,855.0 мянган төгрөгийн зээлийг олгосон байна. Үүнд:

Сонгон шалгаруулах зөвлөлийн шийдвэргүй

- Сүхбаатар сум 2013 онд 4,000.0 мянган төгрөгийн 1, 2014 онд 15,000.0 мянган төгрөгийн 1, 2015 онд 31,000.0 мянган төгрөгийн 4,
- Зүүнбүрэн сум 2011 онд 50,000.0 мянган төгрөгийн 20, 2012 онд 11,900.0 мянган төгрөгийн 8,
- Сайхан сум 2011 онд 110,000.0 мянган төгрөгийн 31, 2012 онд 5,000.0 мянган төгрөгийн 1,
- Шаамар сум 2016 онд 15,500.0 мянган төгрөгийн 9,
- Цагааннуур сум 2011-2016 онуудад нийт 98,000.0 мянган төгрөгийн 21 зээлийг тус тус сонгон шалгаруулах зөвлөлийн шийдвэргүйгээр олгосон байна.
- Сүхбаатар сумын сонгон шалгаруулах зөвлөлөөс 2013 онд нэг зээлдэгчид 4,500.0 мянган төгрөгийг олгохоор шийдвэрлэсэн байхад дараа онд нэмж 3,500.0 мянган төгрөгийг олгосон байна.

Засаг даргын захирамжгүй

- Мандал сум 2011 онд 263,055.0 мянган төгрөгийн 14,
- Зүүнбүрэн сум 2011 онд 50,000.0 мянган төгрөгийн 20, 2012 онд 11,900.0 мянган төгрөгийн 8,
- Сайхан сум 2011 онд 110,000.0 мянган төгрөгийн 31, 2012 онд 5,000.0 мянган төгрөгийн 1,
- Шаамар сум 2011 онд 60,000.0 мянган төгрөг 10, 2014 онд 11,000.0 мянган төгрөгийн 1,
- Хушаат сум 2011 онд 50,000.0 мянган төгрөгийн 19,
- Баруунбүрэн сум 2011 онд 50,000.0 мянган төгрөгийн 32, 2012 онд 38,500.0 мянган төгрөгийн 23,
- Орхонтуул сум 2011 онд 65,300.0 мянган төгрөгийн 23, 2012 онд 12,500.0 мянган төгрөгийн 5,
- Сүхбаатар сум 2015 онд 6,600.0 мянган төгрөгийн 2, 2016 оны 8,000.0 мянган төгрөгийн 1 зээлийг тус тус захирамжгүйгээр олгосон байна.

⁶ Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолоор баталсан журмын 3.2.2. санд ирүүлсэн төслүүдээс энэхүү журмын 3.1.1. заасан чиглэлд нийцсэн, төсөл сонгон шалгаруулах зөвлөлөөс шалгаруулсан төсөлд зээл олгох шийдвэр гаргах; 4.4. Зөвлөл нь иргэн, аж ахуйн нэгжийн ирүүлсэн төслийг энэхүү журмын 4.1, 4.2-т заасан шалгуур, шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянан үзэж, зөвлөлийн хурлаараа хэлэлцэн шийдвэрлэнэ.

Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан журмын 3.5.2. энэ журамд заасны дагуу зээл олгох шийдвэр гаргах; 4.4. Энэ журмын 3.3.3-т заасан зөвлөл иргэн, хуулийн этгээдийн ирүүлсэн төсөл мөн журмын 4.3-т заасан шалгуурыг хангаж байгаа эсэхийг хянах бөгөөд зөвлөлийн хуралд оролцсон гишүүдийн ердийн олонхийн саналаар зохих шийдвэр гаргана. ...

Цаашид төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааг нийтэд ил тод болгох, иргэдээс ирүүлсэн төслийг хүлээн авч, дэмжигдсэн эсэх талаарх хариуг албан ёсоор өгч байх, журмын дагуу шалгуур үзүүлэлтийг үнэлж баталгаажуулан, зохих баримт, материал бүрдсэн төслийг сонгон шалгаруулж байх шаардлагатай байна.

2.2. Зээлийн гэрээний эрх, үүргийн биелэлт хангалтгүй байгаагаас зээлийг зориулалт бусаар зарцуулах, зээл хугацаандаа төлөгдөхгүй байх зэргээр гэрээний зарим зүйл, заалт хэрэгжээгүй байна.

Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолын 2-р хавсралтаар “Сум хөгжүүлэх сангаас олгох зээлийн гэрээний үлгэрчилсэн загвар”-ыг баталсан байдаг.

Сумдууд зээлийн гэрээг дээрх загварын дагуу байгуулсан боловч гэрээний эрх үүргийн биелэлт хангалтгүй, хариуцлага сул байгаагаас үндсэн зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтрэлт 46.5 хувьтай, хүүгийн эргэн төлөлт хангалтгүй, алданги тооцож барагдуулаагүй, гэрээний зарим заалтууд хэрэгжээгүй байна.

Нийт олгосон зээл, зээлийн хүүгийн хугацаа хэтрэлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 8 /мянган төгрөгөөр/

д/д	Сумдын нэр	Нийт олгосон зээл	Төлбөл зохих		Төлсөн эргэн төлөлт		Хугацаа хэтэрсэн	
		Зээл	Зээл	Хүү	Зээл	Хүү	Зээл	Хүү
1	Алтанбулаг сум	409,000.0	409,000.0	21,097.0	180,199.4	17,597.1	228,800.6	3,499.9
2	Баруунбүрэн сум	329,800.0	329,800.0	14,831.4	167,859.5	4,896.4	50,117.0	4,326.0
3	Баянгол сум	426,700.0	426,700.0	19,685.2	145,521.2	16,152.3	168,105.4	3,828.0
4	Ерөө сум	438,440.0	328,612.2	23,060.7	166,367.2	17,734.1	162,245.0	5,326.6
5	Жавхлант сум	253,170.0	203,140.0	17,946.8	82,866.5	9,285.9	120,273.5	8,660.9
6	Зүүнбүрэн сум	256,700.0	224,659.3	7,222.1	103,933.9	3,522.8	120,725.4	3,699.3
7	Мандал сум	1,180,302.0	1,026,838.6	75,285.2	252,399.7	35,519.8	774,438.9	71,209.3
8	Орхон сум	432,120.0	350,041.5	15,974.3	280,916.2	13,118.5	69,125.3	2,855.8
9	Орхонтуул сум	281,250.0	281,250.0	26,858.1	85,764.9	4,308.5	119,958.1	15,904.8
10	Сант сум	277,983.0	198,500.0	11,957.7	107,512.0	6,435.8	90,988.0	5,521.9
11	Сайхан сум	529,050.0	410,578.3	38,479.0	143,285.7	11,109.9	267,292.6	27,369.1
12	Сүхбаатар сум	1,915,197.0	1,240,291.6	112,511.7	1,002,154.6	68,925.4	238,017.0	12,682.1
13	Хушаат сум	206,300.0	206,300.0	8,839.9	60,970.2	3,819.0	145,329.8	5,020.9
14	Хүдэр сум	258,500.0	192,500.0	8,161.7	122,133.3	6,200.0	70,366.7	1,961.7
15	Түшиг сум	275,500.0	205,510.0	11,907.3	96,466.2	4,562.6	109,043.8	7,344.7
16	Цагааннуур сум	390,000.0	390,000.0	23,053.2	182,932.4	15,282.8	207,067.6	7,770.4
17	Шаамар сум	291,500.0	233,000.0	17,282.4	76,583.0	3,995.0	156,417.0	13,287.4
Нийт дүн		8,151,512.0	6,656,721.5	454,153.7	3,257,865.9	242,465.9	3,098,311.7	200,268.8

Хүснэгтээс харахад үндсэн зээлээс 3,098,311.7 мянган төгрөгийн, тооцсон хүүгээс 200,268.8 мянган төгрөгийн эргэн төлөлт хугацаа хэтэрсэн байна.

Нийт хугацаа хэтэрсэн зээлээс бүрэн төлөгдөх хугацаа дууссан 2,499,902.1 мянган төгрөгийн 627 зээл байгаагаас 0.8 хувь буюу 7 сумын 19,778.7 мянган төгрөгийн зээлийг төлүүлэх талаар ямар нэгэн арга хэмжээ аваагүй бол 50.8 хувь буюу 1,236,944.0 мянган төгрөгийн 374 зээлдэгчид мэдэгдэл өгч, 48.4 хувьд шүүхийн шийдвэр гарсан байна.

Бүрэн төлж дуусах хугацаа хэтэрсэн зээлийн шийдвэрлэлтийн байдал:

Хүснэгт 9 /мянган төгрөгөөр/

д/д	Сумдын нэр	Нийт		Зээлээ бүрэн төлж дуусах хугацаа хэтэрсэн зээлийн шийдвэрлэлт							
		тоо	Зээл	мэдэгдэл өгсөн		шүүхэд шилжүүлсэн		шүүхийн шийдвэр гүйцэтгэлд шилжүүлсэн		ямар ч арга хэмжээ аваагүй	
				тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Алтанбулаг	22	102,468.4	0	-	17	96,856.5	5	5,611.9	0	-
2	Баруунбүрэн	24	55,628.0	9	5,589.0	15	50,039.0	0	-	0	-
3	Баянгол	12	171,933.4	1	5,887.6	8	118,922.0	2	42,282.9	1	4,840.9
4	Ерөө	44	113,471.5	27	102,439.1	2	7,716.3	0	-	15	3,316.1
5	Жавхлант	31	97,775.1	31	97,775.1	0	-	0	-	0	-
6	Зүүнбүрэн	63	82,759.2	53	59,110.8	1	1,167.6	9	22,480.8	0	-
7	Мандал	25	675,861.1	8	334,653.2	14	242,207.9	3	99,000.0	0	-
8	Орхон	16	11,120.5	1	3,149.1	5	7,311.3	0	-	10	660.1
9	Орхонтуул	27	135,862.9	0	-	25	128,871.5	1	4,995.4	1	1,996.0
10	Сант	21	66,340.4	2	7,420.1	14	44,090.5	5	14,829.8	0	-
11	Сайхан	72	251,595.3	62	197,412.8	10	54,182.5	0	-	0	-
12	Сүхбаатар	85	250,699.1	52	101,979.4	32	148,713.1	0	-	1	6.6
13	Хушаат	33	110,137.4	21	79,455.5	4	13,579.9	5	13,205.0	3	3,897.0
14	Хүдэр	37	62,036.6	19	37,974.0	1	4,090.2	12	14,910.4	5	5,062.0
15	Түшиг	48	99,452.6	26	69,529.3	22	29,923.3	0	-	0	-
16	Цагааннуур	22	64,727.8	22	64,727.8	0	-	0	-	0	-
17	Шаамар	45	148,032.8	42	133,471.1	1	9,645.6	2	4,916.1	0	-
	Нийт дүн	627	2,499,902.1	376	1,300,573.9	171	957,317.2	44	222,232.3	36	19,778.7

Аудитын явцад тулган баталгаажуулалт хийхэд зээлийн гэрээтэй холбоотой дараах анхаарал татахуйц асуудлууд оршиж байна. Тодруулбал:

- Зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн тохиолдолд алданги тооцох хэмжээ, хугацааг харилцан адилгүйгээр, тухайлбал зарим сумд алданги тооцох талаар гэрээнд тусгаагүй байхад зарим нь сараар, жилээр, нийт зээлийн үлдэгдлээс 0.05-10 хүртэлх хувиар тооцохоор тусгасан байна.
- Зээлийн гэрээнд зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй, зээлдэгчид харьяаллаа солих тохиолдолд зээл, зээлийн хүүг хэрхэн бүрэн төлүүлж дуусгах, хугацаандаа төлөгдөөгүй тохиолдолд харилцах данснаас үл маргах журмаар төлүүлэх, батлан даагчтай байлгах зэрэг заалтыг гэрээнд тодорхой байдлаар тусгаагүй байна. Тухайлбал:
- 11 сумын зээлийн гэрээнд зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй бол хугацаанаас өмнө буцаан төлүүлнэ гэсэн заалт байгаа ч хэрэгжилтийг хангаагүй бөгөөд Баянгол, Зүүнбүрэн, Мандал, Орхон, Орхонтуул, Хүдэр зэрэг 6 сум энэ талаар заалт оруулаагүй байна,
- Зээл авсан иргэн, аж ахуйн нэгж шилжих тохиолдолд зээлийн үлдэгдлийг бүрэн төлж барагдуулах талаар Баруунбүрэн, Мандал, Түшиг, Хушаат, Шаамар зэрэг 5 сумын зээлийн гэрээнд тусгасан бол бусад сум тусгаагүй,
- Зээлийн үүргийн биелэлтийг хангуулах батлан даагчтай холбоотой заалтыг Алтанбулаг, Жавхлант, Зүүнбүрэн, Мандал, Орхон, Сант, Сүхбаатар, Түшиг, Хүдэр зэрэг 9 сумын зээлийн гэрээнд тусгасан бөгөөд бусад сум тусгаагүй.
- Зээлийн эргэн төлөлтийг хангуулах үүднээс зээлдэгчийн харилцах данснаас үл маргах журмаар төлүүлэх заалтыг 14 сумын зээлийн гэрээнд тусгасан ч зээлийг үл маргах журмаар төлүүлсэн тохиолдолд гараагүй байна. Харин Жавхлант, Мандал, Хушаат зэрэг 3 сумын зээлийн гэрээнд энэ талаарх заалтыг оруулаагүй байна.
- Сайхан сум зээлийн эргэн төлөлтийн хуваарийг албан ёсоор баталгаажуулж, гэрээнд хавсаргаагүй байна.

2011-2012 онуудад СХС-гаас олгосон 108 зээлийг барьцаа хөрөнгөгүй олгож байсан бөгөөд 2012 оноос хойш барьцаа хөрөнгийн гэрээг хийж байгаа ч уг гэрээг улсын бүртгэлээр батлуулаагүйгээс гадна улсын бүртгэлд бүртгэгдээгүй үл хөдлөх

хөрөнгө, гэрчилгээний хуулбарыг барьцаа хөрөнгөд авах, хөдлөх хөрөнгийн / машин техник, мал амьтан, гэрийн тавилга / эзэмших эрхийг шилжүүлэхгүй байх, газар эзэмших эрхийг Газрын албанд бүртгүүлэхгүй байх зэрэг зөрчил түгээмэл байгаа нь барьцаалсан хөрөнгүүд бодит байдал дээр барьцаалагдаж чадахгүй байх эрсдэлийг дагуулж байна. Өөрөөр хэлбэл барьцаалсан хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах, бусдад шилжүүлэх эрх нь зээл авсан иргэн, аж ахуйн нэгжид хэвээр хадгалагдаж, зээл төлөх хөшүүрэг болж чадахгүйгээс зээлийн эргэн төлөлт хангалтгүй байна.

2011 оноос хойш аймгийн хэмжээнд 1542 зээл олгосноос 422 зээл бүрэн төлөгдөж хаагдсан бөгөөд 1344 зээлийн барьцаа хөрөнгийн 38.8 хувь болох 563 нь барилга, орон сууц, 22.3 хувь буюу 324 нь газар өмчлөх эрх, 14.9 хувь буюу 217 нь газар эзэмших эрх, 7.8 хувь буюу 113 нь хөдлөх хөрөнгө /суудлын болон ачааны авто машин, трактор, мотоциклүүд/, 5.7 хувь буюу 83 нь мал амьтан, 1.5 хувь буюу 22 нь гэр ахуйн тавилга хэрэгсэл, 1.6 хувь буюу 22 нь бусад хөрөнгө байна.

Нийт барьцаа хөрөнгийн судалгаа:

Хүснэгт 10

д/д	Сумын нэр	Зээлдэг чийн тоо	Үүнээс хаагдсан зээлдэгчийн тоо	Барьцаа хөрөнгийн задаргаа /тоо ширхэгээр/													2016 оны байдлаар байвал зохих барьцаа хөрөнгийн	Үүнээс гэрчилгээг эх хувиар нь аваагүй
				Байр орон сууц барилга	Газар өмчлөх эрх	Газар эзэмших эрх	Хөдлөх хөрөнгө	Мал амьтад	5 ханатай гэр	ногооны зоорь	гахайн, тахианы ферм	гүний худаг	Гэр ахуйн тавилга хэрэгсэл	чацарганы мод	Барьцаа хөрөнгө байхгүй			
1	Алтанбулаг	51.0	7	33	14	7	2	1							10	67		
2	Баруунбүрэн	120.0	65	27	3	10	12	6	4			2	1	5	4	74		
3	Баянгол	29.0	5	27	10	2	5	1			2	1		1	0	49		
4	Ерөө	74.0	7	45	3	1	10	6			1				18	84		
5	Жавхлант	56.0	14	20	0	3	0	8	1	1					10	43		
6	Зүүнбүрэн	93.0	23	14	3	3	26	17	2				1		10	76		
7	Мандал	70.0	10	43	16	18	1								1	79		
8	Орхон	78.0	55	12	21	5									1	39		
9	Орхонтуул	76.0	11	23	38	3	5	10					4		5	88		
10	Сант	60.0	5	16	1	1	10	5			1				21	55		
11	Сайхан	116.0	22	14	21	26	2	3	1							67	29	
12	Сүхбаатар	356.0	119	150	106	70					2	2				330	25	
13	Хушаат	50.0	7	25	32	12	22	16					11	1	3	122		
14	Хүдэр	85.0	36	21	18	7	10	6							10	72		
15	Түшиг	83.0	12	27	14	15	5	3	1						9	73		
16	Цагааннуур	64.0	20	40	2	9	3	1								55		
17	Шаамар	81.0	4	26	22	25									6	79		
Нийт дүн		1,542.0	422	563	324	217	113	83	8	6	6	1	22	1	108	1452	55	
Нийт дүн %				38.8	22.3	14.9	7.8	5.7	0.6	0.4	0.4	0.1	1.5	0.1	7.4	100.0		

Бусдын эзэмшилд буй үл хөдлөх хөрөнгийн итгэмжлэлийг зээлийн хугацаатай адил 3 жилээр хийж байгаа нь тухайн зээлдэгч 3 жилийн хугацаанд зээлээ төлөөгүй тохиолдолд уг итгэмжлэгдсэн барьцаа хөрөнгийг барьцаалагчийн өмчлөлд авч, худалдаалах замаар зээл, зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүү, бусад гарсан зардлыг нөхөх боломжийг алдагдуулж байгаа бөгөөд барьцаалсан хөрөнгийн гэрчилгээг эх хувиар нь хавсаргаагүй, барьцаалсан хөрөнгөөс өөр хөрөнгийн гэрчилгээ хавсаргасан, барьцаа хөрөнгийг өөрчлөхдөө гэрээнд өөрчлөлт оруулаагүй, бүртгэл хөтлөөгүй зэрэг зөрчлүүд ч нийтлэг байдлаар оршиж байна.

Өөрөөр хэлбэл зээлийн барьцаанд барьцаа болох эрх зүйн чадамжгүй хөрөнгүүдийг авч байгаа нь олгосон зээл хугацаандаа эргэн төлөгдөхгүй байх үндсэн нөхцөл болж байна.

2.3 СХС-гаас олгосон зээлийн 41.6 хувийг зориулалтын дагуу ашиглаагүй байна.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2011-2016 онд олгогдсон 8,151,512.0 мянган төгрөгийн 1542 зээлийг жилд 0-3 хувийн хүүтэй, 2-3 жилийн хугацаатай олгосон байна.

Тухайлбал Зүүнбүрэн сум 2013-2015 онд 1 хувийн, Хушаат сум 1.5 хувийн хүүтэй олгож байгаа бол бусад сумд 2-3 хувийн хүүтэй олгосон байна. 2016 онд шинэчлэн батлагдсан журмын заалтыг⁷ зөрчиж Орхон сум 3 иргэнд 10,060.0 мянган төгрөгийн зээлийг ямар ч хүүгүйгээр, Шаамар сум 1 хувийн хүүтэйгээр 10 иргэнд иргэнд 23,500.0 мянган төгрөгийн зээлийг олгосон байна.

Аудитын явцад сумдаас судалгаа авч үзэхэд нийт олгосон зээлийн 11.5 хувь буюу 936,350.0 мянган төгрөгийн 233 төслийг зориулалтын дагуу ашиглаагүй, үйл ажиллагаа огт явуулаагүй бол 4.7 хувь буюу 384,100.0 мянган төгрөгийн 89 төсөл хэрэгжиж байгаад зогссон, 2.5 хувь буюу нэг удаагийн шинжтэй 201,165.0 мянган төгрөгийн 38 төсөл хэрэгжээд дууссан бол 16.9 хувь буюу 1,375,623.0 мянган төгрөгийн 267 төсөл түр зогссон гэсэн дүн, мэдээ ирүүлжээ.

СХС-гаас олгосон зээлийн ашиглалт:

Хүснэгт 11

д/д	Үзүүлэлт	Зээлд эгчийн тоо	Мөнгөн дүн /мян.төг/	Эзлэх хувь
1	Хэрэгжиж байгаа төсөл	823	4,764,224.0	58.4
2	Зээлийн зориулалтыг өөрчлөн хэрэгжиж байгаа	92	490,050.0	6.0
3	Үйл ажиллагаа нь түр зогссон	267	1,375,623.0	16.9
4	Нэг удаагийн шинжтэй хэрэгжээд дууссан	38	201,165.0	2.5
5	үйл ажиллагаагаа явуулж байгаад зогссон	89	384,100.0	4.7
6	Зээлийг огт ашиглаагүй, зориулалт бусаар зарцуулсан	233	936,350.0	11.5
Нийт дүн		1542	8,151,512.0	100.0

Харин 58.4 хувь буюу 4,764,224.0 мянган төгрөгийн 823 төслийг зориулалтаар нь, 6 хувь буюу 490,050.0 мянган төгрөгийн 92 төслийн зориулалтыг өөрчлөн ашиглаж байна.

Зээлийн ашиглалтын дундаж хувь 53.4 байгаа бөгөөд хамгийн өндөр нь Хушаат сумын нийт зээлдэгчдийн 84.0 хувь, Мандал сум 77.1 хувь, Сант 70.0 хувь, Зүүнбүрэн сум 61.3 хувь, Орхон сум 60.0 хувь нь үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа бол Ерөө сум хамгийн бага буюу 33.8 хувьтай байна. Бусад сумд 41.0-57.6 хувийн хэрэгжилттэй байна.

Нийт олгосон зээлийн 15.1 хувийг зориулалт бусаар зарцуулж, төслийн дагуу үйл ажиллагаагаа явуулаагүй бөгөөд үүний дотор Жавхлант сум 44.6 хувийг, Түшиг 43.4 хувийг, Хүдэр сум 30.6 хувийг, бусад сумд 2.9-23.3 хувийг зориулалт бусаар зарцуулсан байна.

⁷ Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 1.6.1. Зээлийн хүүгийн хэмжээ нь жилд 3 хувь байна. /Энэ нь өмнөх жилүүдэд байгуулсан зээлийн гэрээнд заасан хүүгийн хэмжээг өөрчлөх үндэслэл болохгүй./

Аудитын явцад сумдад ажиллан, зээлийн ашиглалт, эргэн төлөлтийн байдалтай танилцаж, дүгнэхэд дараах байдалтай байлаа. Үүнд:

- Мандал сумын иргэн С.Батболд тус сангаас авто засварын газар байгуулах чиглэлээр авсан 26000,0 мянган төгрөгийн, иргэн С. Батбаатар гутлын үйлдвэр байгуулахаар авсан 15000,0 мянган төгрөгийн, Б.Батзориг интернетийн үйлчилгээ үзүүлэхээр авсан 30000,0 мянган төгрөгийн зээлийг зориулалтын дагуу ашигласнаар үйл ажиллагаа нь тогтмолжиж, зээлийн эргэн төлөлтийг хугацаанд нь гүйцэтгэж байна.



Мандал сум

/Чансаа гутлын үйлдвэрийн бүтээгдэхүүнүүд/



Мандал сум

/Авто засварын газар/

- Сүхбаатар сумын иргэн н. Алтанчимэг халуун ус байгуулах чиглэлээр 2013 онд авсан 10000,0 мянган төгрөгийн, н.Намжилмаа номын дэлгүүр ажиллуулах чиглэлээр 2014 онд авсан 4000,0 мянган төгрөгийн зээлийг зориулалтын дагуу ашиглаж, авсан зээлийг хугацаанд нь барагдуулсан байна.
- Баянгол сумын иргэн Л.Батчулуун 2013 онд авсан 17000,0 мянган төгрөгийн, н. Отгон 2014 онд авсан 13000,0 мянган төгрөгийн, Алтанбулаг сумын иргэн н.Бат-Үндэс 2013 онд авсан 10,000 мянган төгрөгийн, Цагааннуур сумын иргэн Д.Лхагвасүрэн 2015 онд авсан 20000,0 мянган төгрөгийн, Сант сумын иргэн О.Долгормаа 15,000,0 мянган төгрөгийн, Сэлэнгэ тоотгоо хоршоо 7000,0 мянган төгрөгийн, Түшиг сумын иргэн Г.Гэрэл 8000,0 мянган төгрөгийн, Л.Шилэнхүү 3000,0 мянган төгрөгийн зээлүүдийг тус тус зориулалтын дагуу ашиглаж, эргэн төлөлтийг гэрээт хугацаанд нь барагдуулсан байна.



Сант сум

/Годон гутал үйлдвэрлэл/



Баянгол сум

/Барилгын материалын худалдаа/

- Мандал сумын иргэн Д.Оюунцэцэг 50000,0 мянган төгрөгийн, Н.Рагчаа 30000,0 мянган төгрөгийн, Түшиг сумын иргэн Ё.Эрдэмбилэг 20000,0 мянган төгрөгийн, Сайхан сумын иргэн Б.Ууганбаяр 18600,0 мянган төгрөгийн, Ж.Мөнхтуяа 15000,0 мянган төгрөгийн, Цагааннуур сумын иргэн Н.Барчулуун 20000,0 мянган төгрөгийн, Баянгол сумын иргэн

Д.Саранмаа 30000,0 мянган төгрөгийн зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй буюу нэг ч төгрөгийн эргэн төлөлт хийгээгүй байна.

Сүхбаатар сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэн Ц.Алтанчимэг мал, амьтан өсгөх чиглэлээр 2011 онд авсан бага хэмжээний буюу дөнгөж 2000,0 мянган төгрөгөөр 2 тугалтай үнээ худалдаж аван үйл ажиллагаагаа эхэлсэн нь өнөөгийн байдлаар 15 үхэр, 60 толгой хонь болж тоо толгой нь өссөний зэрэгцээ, галуу, тахианы аж ахуй эрхэлж, авсан зээлийг хугацаанд нь барагдуулсан байхад тус сангаас их хэмжээний буюу 2013 онд 165000,0 мянган төгрөгийн зээл авсан Мандал сумын иргэн Л.Цэрэнхорол өнөөдрийг хүртэл үйл ажиллагаа явуулаагүй буюу нэг ч төгрөгийн эргэн төлөлт хийгээгүй зэрэг эрс харьцангуй жишээнүүд ч харагдаж байлаа.

Мандал сумын иргэн Ж.Эрдэнэцогт нь “Чулуун эдлэлийн үйлдвэр байгуулах” гэсэн нэг төслөөр “Сум хөгжүүлэх сан”-гаас 2011 онд 49000,0 мянган төгрөгийн “Аймаг хөгжүүлэх сангаас” 2012 онд 31800,0 мянган төгрөгийн зээлийг давхардуулан авсан боловч өнөөдрийн байдлаар үйл ажиллагаа нь явагдаагүй буюу нэг ч төгрөгийн эргэн төлөлт хийгдээгүй байхад зээлийг төлүүлэх талаар сум орон нутгаас хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх зэргээр ямар ч арга хэмжээ аваагүй байна.

Аудитын явцад СХС-гийн зээл олголт, төсөл сонгон шалгаруулалт, ашиглалтын талаар 9 сумын 121 иргэнээс асуулга авахад 76,0 хувь нь тус сангаас жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр зээл олгодог гэдгийг мэддэг боловч 72,7 хувь нь сангийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй мэдээлдэггүй, 63,6 хувь нь зээлийг ашиглах боломжтой иргэдэд олгодоггүй, 56,2 хувь нь олгосон зээл иргэдийн орлого, ажлын байр нэмэгдүүлэх хөшүүрэг болж чаддаггүй, 65,3 хувь нь зээлдэгчид зээлийг зориулалтын дагуу зарцуулдаггүй гэсэн хариултыг өгсөн нь тус сангаас олгосон зээл зорилго зорилтоо хангаж чадахгүй байгааг харуулж байна.

Иргэдийн ирүүлсэн төслөөр нийт 2855 ажлын байр бий болгохоос 2246 буюу 1390 байнгын, 856 түр ажлын байр нэмэгдсэн гэж тайлагнагдсан байна.

Бий болсон ажлын байр:

Хүснэгт 12

д/д	Сумдын нэр	Нийт сонгон шалгаруулсан төсөл /тоо/	Шинээр бий болгохоор төсөвлөсөн ажлын байрны тоо	Шинээр бий болгосон ажлын байрны тоо			
				Нийт ажлын байрны тоо	Үүнээс:		Өнөөг хүртэл хадгалагдсан нь
					Байнгын	Түр	
1	Алтанбулаг сум	51	153	129	60	69	60
2	Баруунбүрэн сум	120	143	143	89	54	15
3	Баянгол сум	29	74	74	36	38	36
4	Ерөө сум	74	196	167	81	86	81
5	Жавхлант сум	56	58	46	16	30	16
6	Зүүнбүрэн сум	93	127	52	38	14	52
7	Мандал сум	70	305	287	287		160
8	Орхон сум	78	122	83	27	56	27
9	Орхонтуул сум	76	126	126	126		47
10	Сант сум	60	116	63	51	12	50
11	Сайхан сум	116	327	133	73	60	41
12	Сүхбаатар сум	356	579	493	365	128	280
13	Хушаат сум	50	102	98	88	10	88
14	Хүдэр сум	85	131	85	27	58	27
15	Түшиг сум	83	91	78	9	69	9
16	Цагааннуур сум	64	119	120	8	112	8
17	Шаамар сум	81	86	69	9	60	9
Нийт дүн		1542	2855	2246	1390	856	1006

Хэдийгээр сумдаас авсан мэдээ, судалгаагаар байнгын ажлын байрны 72.3 хувь нь хадгалагдаж байгаа гэх боловч нийт олгосон зээлийн 38.0 хувьтай тэнцэх 3,098,311.7 мянган төгрөгийн зээл эргэн төлөгдөх хугацаа хэтэрч, зээл авсан иргэн, аж ахуйн нэгжүүд зээлийг эргүүлэн төлөөгүй байгаа нь уг зээлийн эх үүсвэрийг журамд заасан зориулалтын дагуу бүрэн хэмжээгээр ашиглаж, үр дүнд хүрч чадаагүй гэж үзэхэд хүргэж байна.

Бүлэг 3

Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг тайлагнах, хяналт тавих үйл ажиллагаа үр дүнтэй байна уу

СХС-гийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалтын байдалд хяналт шалгалт хийж, өгсөн зөвлөмжийг сумдууд бүрэн хэрэгжүүлээгүй, холбогдох байгууллагуудын зүгээс нэгдсэн бодлого, арга зүйгээр хангаагүй зэргээр байгууллагууд өөр хоорондоо уялдаа холбоо муутай ажиллаж байна.

3.1 Сум хөгжүүлэх сан хариуцсан байгууллагуудын өөр хоорондын уялдаа холбоо хангалтгүй байна.

2016 оноос өмнө мөрдөж байсан Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих журамд зөвхөн сумын удирдлага, хяналтыг хэрэгжүүлэхээр зохицуулагдсан байсан бол шинэчлэн баталсан журамд жижиг дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төв байгууллага, аймгийн Засаг дарга /ЗДТГ-ын жижиг дунд үйлдвэрийн асуудал хариуцсан нэгж/-ын эрхийг тус тус нэмсэн байна.

Аудитын дүнгээс харахад сумын ИТХ-аас журамд заасны дагуу зээл, зээлийн хүүгийн дээд хэмжээ, тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, сонгон шалгаруулах болон хяналтын зөвлөлийг баталж байгаа ч, сум хөгжүүлэх сангийн болон хяналтын зөвлөлийн тайланг хэлэлцэж, тулгамдаж байгаа асуудлуудын талаар шийдвэр гаргаагүй байна.

Сумдын Засаг даргаас журамд заасан эрх, үүргийн дагуу сонгон шалгаруулах зөвлөлийг ахалж, зээл олгох шийдвэрийг гаргаж байгаа ч дараах чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал:

- Төсөл сонгон шалгаруулахад иргэдийн оролцоог хангах,
- Гэрээний биелэлтийг хангуулах, хэрэгжилтийн явц, үр дүнд байнгын хяналт тавьж ажиллах,
- Сангийн үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийг хууль тогтоомжийн дагуу хөтлүүлэх, үйл ажиллагааны тайлан гаргаж, сумын ИТХ-д тайлагнах.

Яамдын бүтцийн өөрчлөлтөөр 2011 оноос хойш СХС-гийн асуудлыг 3 яаманд /ХХААЯ, Хөдөлмөрийн яам, Аж үйлдвэрийн яам/ ээлжлэн шилжүүлснээр аймагт ХХААГ, Хөдөлмөрийн хэлтэс, суманд 2011-2013 оны 04 сар хүртэл ХАА-н тасгийн мэргэжилтэн, 2013 оны 04 сараас 2017 оны 04 сар хүртэл хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн, 2017 оны 04 сараас хойш ХАА-н тасгийн мэргэжилтэн /дарга/ хариуцаж байна.

Журамд СХС-гийн үйл ажиллагааг хариуцсан мэргэжилтний болон санхүү бүртгэл хариуцах ажилтны эрх, үүргийг огт тусгаагүй байгаагаас өнөөгийн байдлаар бүртгэлийг Алтанбулаг, Баянгол, Орхон, Орхонтуул сумдад Санхүүгийн албаны

дарга, Мандал суманд Хэрх тосгоны төрийн сангийн төлөөлөгч, бусад сумдад сумын ЗДТГ-ын нягтлан бодогч нар хариуцан ажиллаж байна.

Аудитын явцаас дүгнэхэд СХС-гийн зохион байгуулалт, явц, үр дүнд төрийн захиргааны байгууллагаас оролцох оролцоо, нэгдсэн бодлого, зохион байгуулалтаар хангах асуудал эрс дутагдаж байна.

Тухайлбал, сангаас олгож байгаа зээлийн хэмжээ хязгаар, хүү, алдангийн хувь хэмжээ, тооцох аргачлал, барьцаа хөрөнгийн нэр төрөл, барьцаалах арга зам тодорхой бус, тус сангаас олгосон зээлийн мэдээллийг Монгол банкны мэдээллийн санд оруулах арга хэмжээ аваагүйгээс сумдууд харилцан адилгүй хэмжээний зээл олгож, зээлийн хүү, алдангийг харилцан адилгүй хувь хэмжээ, аргачлалаар тооцож байгаагаас гадна уг сангаас авсан зээлтэй давхардуулан арилжааны банкнаас зээл авах, банкнаас авсан зээлийг түрүүлж төлж барагдуулан, сангаас авсан зээлийг төлөхгүйгээр хугацаа хэтрүүлэх явдал түгээмэл байдалтай байна.

СХС-гийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалтын байдалд хийгдсэн хяналт шалгалтын зөвлөмжийг сумдууд бүрэн хэрэгжүүлэхгүй байх, холбогдох байгууллагуудын зүгээс нэгдсэн бодлого, арга зүйгээр хангахгүй байх зэргээр байгууллагууд өөр хоорондоо уялдаа муутай ажиллаж байна.

3.2 СХС-гийн зээлийн эргэн төлөлт, хүүг бодитой тооцоолж тайлагнадаггүй, зээлийн хүүгийн орлогыг үр ашиггүй зарцуулдаг зөрчил нийтлэг байдлаар оршиж байна.

Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 3.2.5⁸, 3.5.6⁹, 5.4¹⁰-т заасны дагуу сангийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу хөтөлж, санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг гаргах, сангийн орлого, зарлагын мэдээ тайланг улирал, жилээр гаргаж, ИТХ-д тайлагнаж байхаар тусгасан байна.

Сүхбаатар, Баруунбүрэн, Баянгол, Жавхлант, Шаамар, Орхон, Хүдэр сумд 2015-2016 онуудад СиТиЭс ХХК-иас нэг бүр нь 385.0 мянган төгрөгийн үнэтэй СХС-гийн санхүүгийн програм хангамжийг худалдан авсан боловч уг програм гар ажиллагаа ихтэй, ашиглахад хүндрэлтэй байдаг гэсэн шалтгаанаар өнөөг хүртэл ашиглаагүй байна.

Бүртгэлийн үйл ажиллагаанд програм хангамжийг нэвтрүүлээгүйн улмаас сумдын мэргэжилтнүүд өөрсдөө зохиосон хүснэгтээр бүртгэл хөтөлж байгаа нь зээл, зээлийн хүүгийн тооцоолол зөрүүтэй илэрхийлэгдэх, иргэдээс зээлийн хүүг илүү, дутуу тооцоолж авах, зээлийг бүрэн төлж дуусаагүй байхад хаасан зэрэг зөрчлүүд нийтлэг байдлаар оршиж байна. /Илэрсэн зөрчлийг Хавсралт 2-оор дэлгэрнгүй харуулав/ Үүнд:

⁸ Сангийн үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийг хууль тогтоомжийн дагуу хөтлүүлж, санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг гаргаж, сумын ИТХ-д тайлагнах.

⁹ Сангийн орлого, зарлагыг хөтлөх үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийг мөрдүүлж, сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах.

¹⁰ Сумын Засаг дарга сум хөгжүүлэх сангийн орлого, зарлагын дүн болон зарцуулалтын тайланг улирал, жилээр гаргаж, улирлын эхний 10-ны дотор аймгийн хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газарт хүргүүлнэ. Аймгийн хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрийн газар сумдын тайланг аймгийн хэмжээнд нэгтгэж, улирлын эхний сарын 20-ны дотор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам тайланг улсын хэмжээнд нэгтгэж улирлын эхний сарын 30-ны дотор Сангийн яаманд тус тус хүргүүлнэ.

- Зээлийн эргэн төлөлтийг Алтанбулаг, Баруунбүрэн Цагааннуур, Шаамар зэрэг сумд нийт 64,231.9 мянган төгрөгөөр дутуу, бусад сумд нийт 110,315.6 мянган төгрөгөөр илүү тооцсон байна,
- Зээлийн хүүгийн эргэн төлөлтийг Алтанбулаг, Баруунбүрэн, Мандал, Орхон, Сант, Хүдэр, Жавхлант зэрэг 7 сумд 17,681.0 мянган төгрөгөөр дутуу, бусад сумд 51,201.3 мянган төгрөгөөр илүү тусгасан байна.
- 92 зээлдэгчийн 9,993.9 мянган төгрөгийн хүүгийн орлогыг илүү, дутуу тооцоолсон, 82 зээлдэгчид тооцсон 9,687.3 мянган төгрөгийн алдангийн орлогыг хүүгийн орлогоор бүртгэсэн байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 13 /мянган төгрөгөөр/

д/д	Сумдын нэр	илүү, дутуу тооцсон хүүгийн орлогын тооцоолол		хаагдсан зээлээс тооцсон алданги	
		тоо	дүн	тоо	дүн
1	Алтанбулаг	31	3,456.50	2	4.8
2	Баруунбүрэн	0	-		
3	Баянгол	13	2,282.30		
4	Ерөө			6	1,166.20
5	Жавхлант	6	257.5	10	140.5
6	Зүүнбүрэн			5	400.4
7	Мандал	1	220.9		
8	Орхон			41	6,908.00
9	Орхонтуул	8	129		
10	Сант	0	-	0	-
11	Сайхан	7	1,351.60	4	193.7
12	Сүхбаатар				
13	Хушаат	0	-		
14	Хүдэр				
15	Түшиг	20	1,260.90	6	80.9
16	Цагааннуур	0	-	3	384.7
17	Шаамар	6	1,035.20	5	408.1
Нийт дүн		92	9,993.90	82	9,687.30

- Сүхбаатар сум 2013 онд 2,000.0 мянган төгрөгийн зээлийг давхар олгосныг авлагаар тусгаагүй, санхүүгийн тайлан гаргахдаа авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.
- Мандал сум 2013 онд зээлдэгч Б.Мөнхбаярын зээлийн хүүд 213.6 мянган төгрөгийг илүү төлүүлсэн боловч орлогоор бүртгээгүй, 2015 онд зээлдэгч Д.Хишигжаргалын зээл, зээлийн хүүд 41.9 мянган төгрөгийг, зээлдэгч Ж.Наранхүүгийн зээл, зээлийн хүүд 18.1 мянган төгрөгийг тус тус илүү төлүүлсэн боловч орлогоор бүртгээгүй байна.
- Сайхан сумын 8 зээлдэгч 946.0 мянган төгрөгийг, Алтанбулаг сумын 9 зээлдэгч 732.9 мянган төгрөгийг, Хушаат сумын 3 зээлдэгч 598.4 мянган төгрөгийг, Цагааннуур сумын 3 зээлдэгч 202.8 мянган төгрөгийг, Зүүнбүрэн сумын 7 зээлдэгч 359.9 мянган төгрөгийг, Жавхлант сумын 1 зээлдэгч 114.4 мянган төгрөгийг, Түшиг сумын 2 зээлдэгч 206.7 мянган төгрөгийн зээлийг тус бүр дутуу төлсөн байхад зээлийг хаасан байна.

Журмаар зээлийн хүүгийн орлогын тодорхой хэсгийг сангийн үйл ажиллагаанд зарцуулж болохоор зохицуулагдсан ба уг орлогоос дараах үр ашиггүй зарцуулалтыг гаргасан байна. Үүнд:

- Сүхбаатар сум зээлийн хүүгээс 2011 онд 55,0 мянган төгрөгийг, 2012 онд 2,016.0 мянган төгрөгийг ИТХ-ын шийдвэргүйгээр зарцуулсан, батлагдсан төсвийг 2014 онд 620.5 мянган төгрөгөөр, 2015 онд 47.2 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.
- Сүхбаатар сумын төсөл сонгон шалгаруулах комиссын гишүүдийн ажлын үр дүн, хийсэн ажлын тайлан мэдээг харгалзаж үзэлгүйгээр сар бүр тогтмол

20.0 мянган төгрөгөөр тооцон 2012-2016 онд нийт 12,302.0 мянган төгрөгийн урамшууллыг олгож, СХС-гийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

- Сүхбаатар сумын хяналтын комисс 2014, 2015 онд хяналт тавьж ажиллаагүй байхад нийт 756.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.
- 7 сумын сангийн бүртгэлийн үйл ажиллагаанд СуТиЭс ХХК-иас нийт 2,695.0 мянган төгрөгийн програм худалдан авсан боловч ашиглагдахгүй байна.
- Хяналтын комиссын хийсэн ажлын тайлан гаргаагүй, зээлийн эргэн төлөлт хангалтгүй байхад 2015 онд Мандал сум нийт 1,700.0 мянган төгрөгийн урамшуулал, утасны нэгж, 2013 онд Ерөө сум 30.0 мянган төгрөгийн, Орхон сум 90.0 мянган төгрөгийн, 2014 онд Орхон сум 150.0 мянган төгрөгийн утасны нэгж олгосон байна.
- Хушаат сумын ИТХ-ын 2012 оны 13 дугаар тогтоолоор сумын ойд зориулан баримтат кино хийх зардалд 3,900.0 мянган төгрөгийг, ахмадын өдөрт 785.3 мянган төгрөгийг СХС-гаас зарцуулсан байсныг аймгийн Аудитын газраас зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн байна. 2013 онд сумын Засаг даргын захирамжаар албан байгууллагын дарга, эрхлэгч нар туршлага судлах ажлаар Бээжин хот руу явах зардалд 1,700.0 мянган төгрөг олгосон зөрчилд аймгийн Аудитын газраас акт тогтоож буцааж төлүүлсэн бол өргөдлийн дагуу эмчилгээний төлбөрт 1,000.0 мянган төгрөг олгосон боловч өнөөдрийг хүртэл төлөгдөөгүй байна.
- Алтанбулаг сум СХС-гийн хүүгийн орлогоос үйл ажиллагаанд зарцуулах зардлыг ИТХ-аас баталсан төсвөөс 25.1 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

3.3 СХС-гийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт шалгалт үр нөлөө муутай байна.

Аудитын дүнгээс харахад сумдын СХС хариуцсан мэргэжилтнүүдийн зүгээс олгогдсон зээл, зээлийн хүүг төлүүлэх талаар арга хэмжээ авч, зээлдэгч нартай уулзах, албан шаардлага, мэдэгдэл өгөх, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх зэргээр тодорхой ажил зохион байгуулсан байна.

Сум хөгжүүлэх сангийн журамд заасны дагуу ИТХ-аас томилсон хяналтын зөвлөл жилд 2-оос доошгүй удаа хяналт шалгалт хийж, ИТХ-аар хэлэлцүүлэн, нийтэд ил тод мэдээлэх, шаардлагатай тохиолдолд бусад мэргэжлийн байгууллагаар хяналт хийлгэхээр зохицуулагдсан байдаг.

Аудитад хамрагдсан хугацаанд Баянгол, Зүүнбүрэн, Сант, Цагааннуур, Сайхан, Жавхлант, Хушаат, Хүдэр, Алтанбулаг, Сүхбаатар сумын хяналтын зөвлөлөөс 1-6 удаа хяналт хийж, дүнг сумын ИТХ болон Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж, зээлдэгч нарт хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах мэдэгдэл өгөх, хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх зэрэг арга хэмжээ авч иржээ.

Харин дээрхээс бусад 8 сум / Баруунбүрэн, Ерөө, Орхон, Орхонтуул, Мандал, Шаамар, Цагааннуур, Түшиг / -ын хяналтын зөвлөл хяналт шалгалт огт хийгээгүй, сумын иргэдийг мэдээллээр хангаагүй байгаа нь холбогдох журмыг¹¹ зөрчиж байна.

Алтанбулаг, Зүүнбүрэн, Сайхан сумдын ИТХ нь 2011, 2012, Сүхбаатар сумын ИТХ нь 2012, 2015 онд Мандал сумын ИТХ нь 2014, 2015 онуудад СХС-гийн

¹¹ "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам"-ын 5.3-т "Энэхүү журмын 3.1.5-д заасан ажлын хэсэг сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, зээлийн гэрээний хэрэгжилтэд тухайн санхүүгийн жилд 2-оос доошгүй удаа шалгалт хийж, дүнг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж, сумын нийт иргэдэд мэдээлж байна"

хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус ажлын хэсгийг сумын ИТХ-ын төлөөлөгчөөр ахлуулан байгуулаагүй байгаа нь ЗГ-ын 2011 оны 134 дүгээр тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 3.1.5¹² дахь заалтыг зөрчсөн байна.

Мандал, Сант, Сайхан, Зүүнбүрэн сумдад аймгийн ХХААЖДҮГ, МХГ-аас хяналт шалгалт хийгдэж, хугацаа хэтэрсэн зээлийн зээлдэгчидтэй уулзах, эргэн төлөгдөх график гаргуулах, шүүхэд шилжүүлэх зэргээр арга хэмжээ авч ажилласан байна.

Аж үйлдвэрийн яамнаас СХС-гийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалтын байдалд 2015, 2016 онуудад шалгалт хийж, 2016 оны 04-р сарын 20-ны өдөр сумдад 13 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн боловч зөвлөмжийн дараах 5 заалтыг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- Санхүүгийн тайлан, мэдээг хууль тогтоомжийн дагуу хөтөлж ажиллах, шаардлага хангахгүй, зөрүүтэй тооцоолол, алдаатай байгаа тоог засах,
- Төслийг сонгон шалгаруулахдаа шалгуур үзүүлэлтийг баримталж зах зээлийн эрсдэлийг судалж, төсөл бүрт үнэлгээ өгч байх,
- Шүүхийн шийдвэрийг сайн дураараа биелүүлээгүй зээлдэгчийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан төлүүлэх бөгөөд шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбогдон гарах зардал, шийдвэр гүйцэтгэгчийн урамшууллын асуудлыг зээлдэгч бүрэн хариуцаж төлөх зохицуулалтыг гэрээнд нэмж тусгах,
- Хугацаа хэтрэлттэй, эргэн төлөлтгүй зээлийн талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, хяналт тавих. Зээлийн хугацаа дууссан төлөөгүй зээлдэгчдийг яаралтай шүүхэд шилжүүлэх, Сум хөгжүүлэх санг хохиролгүй болгох арга хэмжээ авах,
- Төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүд “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн зохицуулалтыг мөрдөж ажиллах. Зөвлөлийн гишүүний хамаарал бүхий этгээд төсөл ирүүлсэн тохиолдолд уг төсөлд санал өгөх эрхээс татгалзаж энэ тухай тэмдэглэл үйлдэх.

Дээр дурдсанчлан холбогдох байгууллагуудаас СХС-гийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, олгосон зээлийг эргэн төлүүлэх талаар тодорхой ажил зохион байгуулж байгаа боловч эдгээр нь үр дүнд хүрэхгүй байгаагаас хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл буурахгүй байна.

Иймээс уг сангийн үйл ажиллагааг хэвийн явуулах, сангийн зорилго, зорилтыг хангах, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг бууруулахын тулд зээлийг олгосны дараа үр нөлөө муутай хяналт шалгалт хийх бус олгохоос өмнөх судалгаа, шинжилгээ, үнэлгээний ажлыг бодитой болгох, хууль, эрх зүйн чадамж бүхий хангалттай хэмжээний барьцаа хөрөнгө авч үлдэх, зээлийн мэдээллийг Монгол банкны мэдээллийн санд оруулах зэрэг огт хийгдэхгүй байгаа үр нөлөө бүхий арга хэмжээг холбогдох байгууллагуудаас нэгдсэн бодлогоор хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

¹² Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавих чиг үүрэг бүхий 7 хүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус ажлын хэсгийг сумын ИТХ-ын төлөөлөгчөөр ахлуулан байгуулна. Ажлын хэсгийг байгуулахдаа ИТХ-ын тогтоол гаргана.

АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ

СХС-гийн 2011-2016 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар нийт **4,510,289.2 мянган төгрөгийн** зөрчил илэрснээс **3,160.1 мянган төгрөгийн** зөрчилд нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож, **1,162,299.7 мянган төгрөгийн** зөрчлийг арилгуулах албан шаардлага, **3,344,829.4 мянган төгрөгийн** зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлж байна. / Хавсралт 3-т дэлгэрэнгүй харуулав/

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цулуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Сум хөгжүүлэх сангаас олгох зээлийг хэт жижиглэн, ижил төрлийн үйл ажиллагаанд олон тоогоор олгож байгаа нь тус сангийн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, өргөтгөх, ажлын байр нэмэгдүүлэх үндсэн зорилгыг хангаж чадахгүйд хүргэж байна.
- Зээлийг гэрээт хугацаанд нь төлүүлээгүйгээс 2,499,902.1 мянган төгрөгийн хөрөнгийг эргэлтэд оруулах, алданги, торгуулийн орлогыг тухай бүр тооцоолоогүйгээс 105,907.0 мянган төгрөгийн орлого нэмэгдүүлэх боломжуудыг алдсан байна.
- Сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүдийг шинэчлээгүй, хуралд гишүүд бүрэн оролцдоггүй, хурлын тэмдэглэл, шийдвэрийг гарын үсгээр баталгаажуулаагүй, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргаагүй, иргэдээс төсөл хүлээн авч, хариу өгсөн тухай бүртгэл хөтлөөгүй байгаа зэрэг нь сонгон шалгаруулалт нийтэд ил тод, шударга явагдахгүй байх, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг үүсгэж байна.
- Төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөл нь зээлдэгчийн төлбөрийн болон үйл ажиллагаа явуулах чадварыг нарийвчлан бодитой үнэлж, судалгаа хийгээгүй, сонгон шалгаруулсан төслийн үзүүлэлт нь тодорхой бус байхад зээл олгох шийдвэр гаргаж байгаа нь зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд сөргөөр нөлөөлж байна.
- Зээлийн барьцаанд барьцаа болох эрх зүйн чадамжгүй хөрөнгүүдийг авч байгаа нь олгосон зээл хугацаандаа эргэн төлөгдөхгүй байх үндсэн нөхцөл болж байна.
- СХС-гаас олгосон зээлийн 41.6 хувийг зориулалтын дагуу ашиглаагүй байна.
- СХС-гаас олгосон зээлийн 46,5 хувь нь эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн байна.
- Сангаас олгож байгаа зээлийн хэмжээ, хязгаар хүү, алдангийн хувь хэмжээ, тооцох аргачлал, барьцаа хөрөнгийн нэр төрөл, барьцаалах арга зам тодорхой бус байгаагаас сумдууд харилцан адилгүй хэмжээний зээл олгож, зээлийн хүү, алдангийг харилцан адилгүй хувь хэмжээ, аргачлалаар тооцож байна.
- СХС-гаас олгосон зээлийн мэдээллийг Монгол банкны мэдээллийн санд оруулах арга хэмжээ аваагүйгээс уг сангаас авсан зээлтэй давхардуулан арилжааны банкнаас зээл авах, банкнаас авсан зээлийг түрүүлж төлж барагдуулан, сангаас авсан зээлийг төлөхгүйгээр хугацаа хэтрүүлэх явдал түгээмэл байдалтай байна.

- СХС-гийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалтын байдалд хийгдсэн хяналт шалгалтын зөвлөмжийг сумдууд бүрэн хэрэгжүүлэхгүй байх, холбогдох байгууллагуудын зүгээс нэгдсэн бодлого, арга зүйгээр хангахгүй байх зэргээр байгууллагууд өөр хоорондоо уялдаа холбоо муутай ажиллаж байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга Б.Мөнхтөрд:

1. 2016 онд шинэчлэн батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн журам”-ыг мөрдөн, Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, зээлийн хэмжээ хязгаар, зээлийн хүү, алданги тооцох арга зүй, барьцаа хөрөнгийн төрөл, түүний эрх зүйн чадамжийг хангах нэгдсэн бодлого, аргачлалаар сумдыг хангах.
2. Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, бүртгэл тооцоолол, хяналт шалгалт хариуцсан байгууллагуудын өөр хоорондын уялдаа, холбоог хангах.
3. СХС-гийн үйл ажиллагаа, бүртгэл тооцоог хариуцсан ажилтны үйл ажиллагаанд хяналт тавих, холбогдох сургалтад хамруулах,
4. Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн мэдээллийг Монгол банкны мэдээллийн санд оруулах, зээл төлүүлэх хөшүүрэг болж чадах эрх зүйн чадамж бүхий хөрөнгүүдийг барьцаа хөрөнгөөр авч үлдэх замаар эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг төлүүлэх арга хэмжээ авах.
5. Бусад байгууллагуудтай /банкууд, улсын бүртгэлийн хэлтэс, газрын алба гэх мэт/ хамтран ажиллах харилцааг тодорхой болгож, шаардлагатай тодорхойлолт, лавлагааг тухай бүр авч, зээл олгох шалгуур үзүүлэлт болгон ашиглуулах.
6. Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа хариуцсан төв байгууллагын хувьд сумдын сангийн үйл ажиллагаа, үр дүн, зээлийн эргэн төлөлт, бүртгэл тооцоололд үр нөлөө бүхий хяналтыг тогтмол тавьж байх.

Сумдын ИТХ-ын дарга нарт:

1. Хяналтын зөвлөл журамд заасан хугацаанд тогтмол шалтгалт явуулж, дүнг ИТХ-аар хэлэлцүүлж, сумын нийт иргэдэд мэдээлж байх.
2. Зээл олголт, ашиглалт, үр дүнд байнгын хяналт тавьж ажиллахын зэрэгцээ хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах тал дээр онцгой анхаарч ажиллах.
3. Зээлийн хүүг журамд заасны дагуу 3 хувиар тооцохоор гэрээ байгуулж байх.
4. Төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлд ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлж, хуулийн хүрээнд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Сумдын Засаг дарга нарт:

1. СХС-гийн эх үүсвэр, эргэлтийг нэмэгдүүлэхийн тулд зээлийн эргэн төлөлтөд тавих хяналтыг сайжруулах, зээл төлүүлэх үр нөлөө бүхий арга хэмжээ авах.
2. Сум хөгжүүлэх сангаас олгох зээлийн менежментийг сайжруулах, үр дүнг нь сум, орон нутгаараа хүртэх томоохон хэмжээний, цөөн тооны төсөл арга хэмжээнд хүрэлцэхүйц хэмжээний зээл олгох бодлого барих.
3. Сум, орон нутгийн зах зээлийн багтаамж, хэрэгцээ, шаардлагыг харгалзан жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэл, тоо хэмжээг тогтоож, төсөл хүлээн авах хугацааг олон нийтэд зарлаж байх.

4. Төсөл сонгон шалгаруулах зөвлөлд оролцох иргэний төлөөллийг багийн иргэдийн Нийтийн хурлаар сонгон, иргэдийн оролцоог хангаж ажиллах.
5. Төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлийн гишүүдийн ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдүүлгийг тухай бүр авч хэвших.
6. Төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлөөс гаргаж буй шийдвэрийг тодорхой болгож, журмын дагуу шалгуур үзүүлэлтээр нь үнэлэх үнэлгээний хуудас баталж, мөрдүүлэх.
7. Иргэдээс ирүүлсэн төслийг хүлээн авч, гарын үсгээр баталгаажуулсан бүртгэл хөтлөх, дэмжигдээгүй төслүүдэд хариуг албан бичгээр өгч байх.
8. Барьцаа хөрөнгийг Улсын бүртгэлийн хэлтэст, газар ашиглах, эзэмших гэрээг Газрын албанд бүртгүүлэх, хөдлөх хөрөнгийн эзэмшлийг барьцаалагчид шилжүүлсний үндсэн дээр зээл олгож байх.
9. СХС-гийн үйл ажиллагааны мэдээллийг иргэдэд ил тод мэдээлэх.

Сум хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтэн болон нягтлан бодогч нарт:

1. Сонгон шалгаруулах зөвлөл болон Засаг даргын шийдвэрийг үндэслэн зээлийн гүйлгээг хийж байх.
2. Зээлийн эргэн төлөлт, үлдэгдэл, хүү, алдангийн ногдуулалт, орлогыг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгах, тайлагнах.
3. Зээлдэгч нарын хувийн хэргийг журмын дагуу бүрдүүлж, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, хугацаа хэтрэлтийн талаарх мэдээллийг холбогдох албан тушаалтнуудад хүргэж байх.
4. Сангийн үйл ажиллагаа болон санхүүгийн баримт, материалыг иж бүрэн бүрдүүлж, архивын нэгж болгон хадгалах.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

АУДИТОР

ШИНЖЭЭЧ

Ч.ЭНХТУЯА

Б.БАТМӨНХ

Б.ЭРДЭНЭЗУЛ

Ц.ОТГОНБАЯР

С.БААСАНСҮРЭН